

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН

2022-2023

2024.05.03



ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН 2022-2023

Бэлтгэсэн:

Л.Галбаатар

Хянан тохиолдуулсан

Б.Онон

Тус тайланг Нээлттэй Нийгмийн Форум болон Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжин хамгаалах олон улсын сүлжээний дэмжлэгтэйгээр бэлтгэв.

Гарчиг

| | |
|----------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Товчилсон үгсийн жагсаалт | 3 |
| ӨМНӨТГӨЛ | 4 |
| НЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН | 5 |
| 1.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа | 5 |
| 1.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа | 7 |
| 1.3. Сэтгүүлчийн нууц эх сурвалж | 9 |
| 1.4. Мэдээллийн эрх чөлөө ба хязгаарлалт | 12 |
| 1.5. Сонгууль ба хэвлэл мэдээлэл | 18 |
| 1.6. Нэр төр гутаахтай холбоотой зохицуулалт | 22 |
| 1.7. Агуулгын хязгаарлалт | 25 |
| 1.8. Бусад зохицуулалт | 27 |
| ХОЁР. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭСРЭГ ИРГЭНИЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ | 30 |
| 2.1. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн эсрэг гомдол, мэдээлэл ба эрүүгийн хэргийн шийдвэрлэлт | 30 |
| 2.2. Сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг мөрдөн шалгах ажиллагаа | 32 |
| 2.3. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн тойм | 34 |
| Хавсралт | 36 |
| Сэтгүүлчийн аюулгүй байдлын талаарх асуулгын судалгааны тойм | 36 |

Товчилсон үгсийн жагсаалт

| | |
|-----------|-------------------------------------------------------|
| ГИТ | Глоб Интернэшнл төв |
| УИХ | Улсын Их Хурал |
| ХЭҮК | Хүний эрхийн Үндэсний Комисс |
| ИБУТЭТОУП | Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт |
| МҮОНРТ | Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз |

ӨМНӨТГӨЛ

Жил бүрийн 5 сарын 3-ны өдөр дэлхий даяар тэмдэглэдэг “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр” (ДХЭЧ)-т зориулан Монгол дахь Хэвлэлийн эрх чөлөөний тайлангаа та бүхэнд толилуулж байна.

ДХЭЧ-ний өдрийг 2024 онд “Гараг ертөнцийн төлөөх хэвлэл: Байгаль орчны хямралтай нүүр тулж буй сэтгүүл зүй” сэдэв дор тэмдэглэж байна. ЮНЕСКО-гийн үзэл баримтлалд дурдсанаар “Цаг уурын өөрчлөлт, биологийн олон төрөл зүйлийн алдагдал, агаарын бохирдол нь гараг ертөнцийн гурвалсан хямрал болж, энэ нь нийтийн эрүүл мэндтэй холбоотойгоор хүн төрөлхтөний голлох эрсдэл болж, ардчиллыг бэхжүүлэх, цахим талбаруудад хуурамч, хуудуутай мэдээллийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай тулгарч байна. Мэдээллийн эко систем өнөөгийн хямрал хариу үйлдэл үзүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ. Найдвартай мэдээлэлтэй байх, байгаль орчин, шинжлэх ухааны хараат бус сэтгүүл зүйг бэхжүүлэх ач холбогдол, урьд урьдынхаас илүү чухал болж байна” хэмээн энэ жилийн сэдвийг онцлоод “2024 оны ДХЭЧ-ний өдрийг дэлхий нийтийн байгаль орчны өнөөгийн хямралт нөхцөл байдалтай уялдуулан сэтгүүл зүй, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ач холбогдлыг цохон тэмдэглэхэд зориулж байна” хэмээжээ.

Монгол Улсад ч байгаль орчны хямрал нүүрлэж, үер, зудын аюул иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд ноцтой хор хохирол учруулав. Манай сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхэн байгалийн гамшгийн тухай шуурхай мэдээлэл мэдээ сурвалжлага бэлтгэн түгээж, сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээллээр хангаж байв. 2023 онд манай байгууллагаас жил бүр олгодог “Үнэний төлөө” шагналыг МҮОНТ-ийн байгаль орчны сэтгүүлч Ц.Цэвээнхэрлэн хүртсэн билээ.

Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар, 2023 оны эцсийн байдлаар манай улсад 400 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 4462 хүн ажиллаж байна. Тэдний 49 хувь нь бүтээлч ажилтан буюу сэтгүүлч, сурвалжлагч байна. Харамсалтай нь, манайд хэвлэлийн эрх чөлөөний эрх зүйн орчин таагүй хэвээр байна. Хэдийгээр УИХ, Засгийн газраас мэдээллийн нээлттэй байдал, ил тод байдал, цахим засаглал, авлигатай тэмцэх тухай ярьж, мэдэгдэл хийн, нааштай зарим арга хэмжээ авч байгаа ч дорвитой үр дүнд хүрээгүй байна. Мэдээллийн ил тод байдлыг хатуу хязгаарлаж буй Төрийн ба албаны нууцын тухай хуульд өнөө хэр нэмэлт өөрчлөлт хийгээгүй байна.

Сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах эрх өнөө хэр хуулиар баталгаажаагүй бөгөөд 2023 онд нийт 386 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтныг оролцуулсан сэтгүүлчийн аюулгүй байдлын судалгаанд эх сурвалжийн аюулгүй байдлын талаар санаа зовниж буй нь тодорхой харагдаж байна. Тодруулбал, 65% нь эх сурвалжийн аюулгүй байдлыг хангах чухал байгааг онцолжээ. Мөн 48% нь эх сурвалжаа нууцлах эрх зөрчигдсөн гэж хариулсан нь 2022 оны судалгаатай харьцуулахад 28 пунктээр өссөн үзүүлэлт харагдаж байна.

УИХ 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд шинэ зохицуулалтаар иргэдийн мэдээлэлтэй байх эрх, сэтгүүл зүйн үйл ажиллагааг үндэслэлгүйгээр, хэтрүүлэн хязгаарлах, цензур тогтоох үр дагавартай болжээ. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан нь өмнөх хуульд байсан хэвлэлийн эрх чөлөөний хатуу хязгаарлалтуудыг хэвээр үлдээн, шинэ хязгаарлалтуудыг нэмсэн нь сонгогчдын эрх ашигт үйлчлэх, тэдний дуу хоолой байх хэвлэл мэдээллийн үүргийг хөсөрдүүлэхэд хүргэж байна.

“Хил хязгааргүй сурвалжлагчид” (RSF) олон улсын байгууллагын Хэвлэлийн эрх чөлөөний индексээр дэлхийн 180 орноос Монгол Улс 2022 онд 90, 2023 онд 88-р байранд жагсаж, хэвлэлийн эрх чөлөөний “мэдэгдэхүйц асуудал”-тай орны тоонд багтсан хэвээр байна.

Х.НАРАНЖАРГАЛ
Глоб Интернэшнл төвийн
Удирдах зөвлөлийн дарга

НЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх, төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт энэхүү эрх чөлөөг хязгаарлах нөхцөлийг тодорхой тусгасан.¹ Тодруулбал, а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагаас үүдэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг хуулиар хязгаарлаж болно гэж заасан. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж зааснаар илэрч байна.

Энд дурдсан “бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх”, “үндэсний аюулгүй байдал”, “нийгмийн хэв журам”, “хүн амын эрүүл мэнд”, “ёс суртахуун”-ыг хэрхэн тодорхойлох, ойлгохоос хамаарч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зүй бусаар хязгаарлах эрсдэлтэй байна. ИБУТЭТОУП-аар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, гэрээний үүргээс ухрахад баримтлах НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1984 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн E/CN.4/1985/4 дугаар тогтоолоор батлагдсан “Сиразуагийн зарчмууд” дээрх ойлголтыг тодорхойлсон.

- “нийтийн хэв журам” гэж нийгмийн үйл ажиллагааны дүрэм журмын нийлбэр буюу нийгмийг үндэслэсэн үндсэн зарчмуудын багц гэж тодорхойлж болно. Хүний эрхийг хүндэтгэх нь нийтийн хэв журмын нэг хэсэг юм. Ийм учраас хүний эрхийг хязгаарлах үндэслэл, зорилгын хүрээнд нийгмийн хэв журмыг тайлбарлана. Нийтийн хэв журмыг сахиулах үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтан эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь парламент, шүүх, бусад эрх бүхий бие даасан байгууллагаар дамжуулан хяналт тавина.
- “нийтийн эрүүл мэнд”-ийг хүн ам, хувь хүмүүсийн эрүүл мэндэд ноцтой аюул заналхийлсэн тохиолдолд төрөөс арга хэмжээ авах боломжийг олгохын тулд тодорхой эрхийг хязгаарлах үндэслэл болгон ашиглаж болно. Эдгээр арга хэмжээ нь өвчин, гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх, өвчтэй, бэртсэн хүмүүст тусламж үзүүлэхэд тусгайлан чиглэсэн байх ёстой. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тогтоосон олон улсын эрүүл мэндийн зохицуулалтыг зохих ёсоор анхаарч үзэх хэрэгтэй.
- “нийтийн ёс суртахуун” нь цаг хугацааны явцад, нэг соёлоос нөгөөд харилцан адилгүй байдаг тул нийтийн ёс суртахууныг хүний эрхийг хязгаарлах үндэслэл болгон ашиглах улс тухайн хязгаарлалт нь нийгмийн суурь үнэт зүйлсийг хүндэтгэн сахилахад зайлшгүй шаардлагатай гэдгийг харуулах ёстой. Энэ нь ялгаварлан гадуурхахгүй байх дүрмийг аль ч тохиолдолд зөрчих ёсгүй.
- “үндэсний аюулгүй байдал”-ыг хангахын тулд тодорхой эрхийг хязгаарлах арга хэмжээ нь зөвхөн тухайн үндэстний оршин тогтнох, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолыг хүч хэрэглэх, хүч хэрэглэх аюулаас хамгаалах үед үндэслэлтэй болно. Хууль, хэв журамд заналхийлж буй орон нутгийн хэмжээний, бусад аюулын үед үндэсний аюулгүй байдлыг хангах нэрийн дор хүний эрхийг хязгаарлаж болохгүй. Үндэсний аюулгүй байдлыг хангах үндэслэлийг тодорхой бус эсвэл дур зоргоороо хязгаарлалт тавих шалтаг болгон ашиглах ёсгүй бөгөөд зөвхөн зохих хамгаалалт, хүчирхийллийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ байгаа тохиолдолд л ашиглаж болно. Хүний эрхийг системтэйгээр зөрчих нь жинхэнэ үндэсний аюулгүй байдлыг алдагдуулж, олон улсын энх

¹ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

тайван, аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй юм. Ийм зөрчлийн эсрэг авах хариу арга хэмжээ нь хүний эрхийг зөрчих үндэслэл болохгүй.

“Сиракузагийн зарчмууд”-ын 10 дугаар зүйлд зааснаар хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь гурван үндсэн шалгуурыг хангах ёстой. Үүнд: 1/ Хүний эрхийг хязгаарлах нөхцөлийг хуулиар тогтоосон байх; 2/ Хүний эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлагатай байх; 3/ Хүний эрхийг хязгаарласан байдал, хэр хэмжээ нь тавьсан зорилгодоо тохирсон байх.²

Гэвч бодит байдал дээр ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хязгаарлалтын шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.2-т “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна” гэж заасан бөгөөд Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг баталсан. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д “... задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэснийг зөрчиж, мэдээлэл авах эрхийг хуулиар биш, Засгийн газрын тогтоолоор хязгаарлаж, хүний эрхийг хязгаарлах нөхцөлийг хуулиар тогтоосон байх шаардлагад нийцээгүй болохыг харуулж байна. Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1-т зааснаар “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх худал мэдээ, мэдээлэл түгээх” нь зөрчил бөгөөд шийтгэл оногдуулна. Ингэхдээ тухайн асуудлаарх эрх бүхий байгууллага, албан тушаалтан урьдчилж бүрэн, цэгцтэй, шинэ мэдээлэл өгсөн эсэхийг харгалзахгүй. Мөн “олон нийтийг төөрөгдүүлэх”, “худал” гэх ойлголтыг тодорхойлох хэмжүүр байхгүй, зөрчлийг шийдвэрлэх албан тушаалтны үзэмжээр тодорхойлогдох эрсдэлтэй байна. Энэ нь хүний эрхийг хязгаарласан байдал, хэр хэмжээ нь тавьсан зорилгодоо тохирсон байх нөхцөлийг хангахгүй байна.

Иймд ХЭҮК-ын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар байгуулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаарх хуулийн төслийн талаар ХЭҮК-ын санал боловсруулах Ажлын хэсгийн бэлтгэж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлийн хавсралтад орсон “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын загвар төсөл”-д үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах шийдвэр, арга хэмжээ нь дээр дурдсан нөхцөл, шаардлагыг хангах эсэхийг холбогдох байгууллага, албан тушаалтан үнэлж, баримтжуулах, үнэлгээний дүгнэлтийг байгууллага, албан тушаалтан өөрийн санаачилгаар эсхүл Комиссын гишүүний саналын дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэх, энэ үнэлгээ хийх аргачлалыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс баталж, хэрэгжилтэд хяналт тавих талаар тусгажээ.³ Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгааг хангахад чиглэсэн бодитой санаачилга болжээ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулган, 2023 оны намрын ээлжит чуулган, 2024 оны хаврын ээлжит чуулганаар тус тус хэлэлцэх асуудлын жагсаалтад “Иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл”-ийг тусгасан байна. Гэвч энэ хуулийн төслийн хувилбар төдийгүй төслийг хэн боловсруулах, ямар үзэл баримтлалтай байх талаар мэдээлэл ил тод бус байна.⁴ Ийнхүү “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д ороогүй төслийг Монгол Улсын Их Хурлын сүүлийн 3 ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулсан нь тус хуулийн төслийн талаарх болгоомжлол бий болгож байна.

² ИБУТЭТОУП-аар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, гэрээний үүргээс ухрахад баримтлах Сиракузагийн зарчмууд. 1984 он. E/CN.4/1985/4 <https://www.refworld.org/docid/4672bc122.html>

³ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэл <https://nhrcm.gov.mn/assets/img/58c1302622c8c88d036544f656fdff5d.pdf>

⁴ Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 сарын 18-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 08 дугаар тогтоол, 2022 оны 07 сарын 07-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 76 дугаар тогтоол, 2024 оны 01 сарын 17-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 16 дугаар тогтоол

1.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023–2030 он/-ийн 3 дахь зорилгод “Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ” гэж заасан бөгөөд 3.4 дэх зорилтод “Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлнэ” гэж, 3.4.1-т “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн батлуулж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгоно.”, 3.4.2-т “Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийг аливаа дарамт, шахалт, сүрдүүлгээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.”, 3.4.3-т “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг баталж, мөрдүүлнэ.”, 3.4.4-т “Сэтгүүлчийн мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлнэ” гэж тус тус заасан.

Эдгээр зорилт, дэд зорилт нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.8, 4.1.5.6, 4.1.8 (4.1.8.1-4.1.8.5)-д заасан зорилт, дэд зорилтыг агуулгын хувьд дахин тусгасан шинжтэй байна. Шинэ хөтөлбөрт нэмэлтээр 6.4.8-д “Хэвлэл мэдээллийн байгууллагын эцсийн өмчлөгч болон санхүү, орлогын эх үүсвэрийн талаарх мэдээллийг ил тод болгох зохицуулалтыг сайжруулна” гэж тусгажээ.

Авлигын эсрэг хуулийн 2¹.1-т “Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална” гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дахь заалтад “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасан. Гэвч тус хөтөлбөрийн 11.1.1-т “Монгол Улсын Засгийн газар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, санхүүжүүлнэ. Яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Монгол Улсын Засгийн газар хариуцан ажиллана” гэж заасан нь ойлгомжгүй байдлыг бий болгожээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 4 дүгээр сарын 10-ны Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлсэн.⁵ Энэ төлөвлөгөөний төсөлд 2027 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн батлуулах, 2026 онд авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийг аливаа дарамт, шахалт, сүрдүүлгээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, 2025 онд төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг батлахаар тусгажээ.⁶ Энэ нь Засгийн газрын хувьд хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхөд алгуур хандаж байгааг харуулж байна. Одоогоор тус төлөвлөгөө батлагдаагүй байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 11.1.4-т Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар нь Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хэрэгжүүлэгч

⁵ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” тогтоолын төслийг өргөн мэдүүлэв <https://www.parliament.mn/nn/52176/>

⁶ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл <https://d.parliament.mn/tusul/bc6d6a88-dbab-4cd0-ad0c-ccd85712a491>

байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлж, санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулах, 11.1.5-д Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тайлан, үнэлгээ, санал, дүгнэлтийг хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгч болно гэж заасан бөгөөд бодит байдалд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, хэлэлцэж байгаа, батлах хууль тогтоомжийн төсөл нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилттой харшилж байгаа эсэхийг хянахгүй байна.

Тухайлбал, Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан. Ингэхдээ Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйл /Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах/-ийн 1 дэх хэсгийг “Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж өөрчлөн найруулсан. Хуулийн төслийг хэлэлцэх явцад энэхүү өөрчлөлтийг хэвлэл мэдээллийн салбарынхан болон иргэний нийгмийн төлөөлөгчид хүчтэй эсэргүүцсэн. Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан энэхүү өөрчлөлтөөр “прокурорын зөвшөөрлөөр” гэх үгийг хасч, зөвхөн албан ёсоор эрүүгийн хэргийн хавтаст хэрэгтэй танилцсан этгээдэд хамаарах зохицуулалтыг хэт өргөжүүлж, мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримтыг хавтаст хэргээс бус өөр эх үүсвэрээс олж мэдсэн хүнд нэгэн адил хамааруулсан нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчиж байна. Учир нь уг зохицуулалт мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үйл ажиллагааны үндсэн дээр болон шүгэл үлээгчээр дамжуулж буюу мэдээллийн нууц эх сурвалжийн дагуу олж мэдсэн аливаа этгээд, тэр дундаа сэтгүүлчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үр дагаврыг нээж байна. Иргэдийн мэдээлэлтэй байх эрх, сэтгүүл зүйн үйл ажиллагааг үндэслэлгүйгээр, хэтрүүлэн хязгаарлах, цензур тогтоох үр дагавартай Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хориг тавихыг хүсэж Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн төлөөх Хуульчдын сүлжээнээс Монгол Улсын Ерөнхийлөгчид хандсан боловч ямар нэг хариу өгөөгүй байна. Энэ үйл явдал нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3.4.2-т заасан “Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийг аливаа дарамт, шахалт, сүрдүүлгээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно” зорилтод нийцэхгүй эрх зүйн зохицуулалт батлагдсан болохыг харуулж байна.

1.3. Сэтгүүлчийн нууц эх сурвалж

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ буюу ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлийн талаар НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан 2011 оны 34 дүгээр Ерөнхий зөвлөмжийн 45 дахь хэсэгт “Гишүүн орнууд мэдээллийн эх сурвалжаа илчлэхгүй байх сэтгүүл зүйн хязгаарлагдмал давуу эрх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний бүрэлдэхүүн болохыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэвэл зохино” гэжээ.⁷ Европын хүний эрхийн шүүхийн жишиг шийдвэрүүдэд “сэтгүүл зүйн эх сурвалжийг хамгаалах нь хэвлэлийн эрх чөлөөний нэг гол нөхцөл юм. Ийм хамгаалалтгүйгээр эх сурвалжийн хувьд олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар олон нийтэд мэдээлэл хүргэхэд хэвлэлд туслахаас татгалзах болно. Үүний үр дүнд хэвлэл мэдээллийн хоточ нохойн амин чухал үүрэг алдагдаж, хэвлэлийн үнэн зөв, найдвартай мэдээлэл өгөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Олон нийтийн ашиг сонирхлын үүднээс нэн тэргүүний шаардлагаар зөвтгөгдөөгүй л бол эх сурвалжийг илчлэх үүрэг хүлээлгэх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тэр дундаа мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийн зохицуулалтад нийцэхгүй” гэж онцолсон.⁸ Мөн “сэтгүүлч нууц эх сурвалжаа хамгаалах эрхийг хөндөхийн тулд шүүхээс зохих үнэлгээ хийж, олон нийтийн бусад ашиг сонирхлыг хангахад сэтгүүлчийн эх сурвалжийг илчлэх нь шууд хамааралтай, зайлшгүй шаардлагатай болохыг нотлох ёстой. Тийнхүү нотлоогүй нөхцөлд сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах эрхийг зөрчсөн гэж үзнэ” гэсэн жишиг тогтсон байна.

УИХ-аас 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр баталж, 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34.2-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 6-д “Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно.”, 7-д “Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй” гэж тус тус зохицуулсан тул мөрдөгч олон нийтийн радио, телевизийн ажилтнаас мэдээллийн эрх сурвалжийг нь асуух, илчлэхийг шаардах нь хууль бус болдог. Гэвч бусад сэтгүүлчээс нууц эх сурвалжийг нь асуух, илчлэхийг шаардахыг хориглосон зохицуулалт байхгүй. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хороодын 2015 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 8 дахь “Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална” гэсэн заалтаар сэтгүүлчдэд нууц эх сурвалжаа хамгаалах ёс зүйн үүргийг хүлээлгэдэг.

Үүний улмаас практикт сэтгүүлчийг төдийгүй түүний эх сурвалжийг дуудах, байцаах явдал түгээмэл болсон. Жишээ нь “Өнөөдөр” сонины unuudur.mn вэб сайтын сэтгүүлч хүний амины ноцтой хэрэг, хар тамхины талаар бодит мэдээлэл бэлтгэсний төлөө мөрдөн байцаах байгууллагын албан тушаалтан утсаар нийтлэлээ устгахыг шаардаж дарамтлах, эх сурвалжаа хэлэх, мэдүүлэг өгөхийг шаардах, улмаар эх сурвалжийг нь хайж олсны дараа эх сурвалжийг таниулахаар дуудах зэргээр ажиллаж байгаа явдал гарч байна.

Глоб интернэшнл төвөөс 2023 онд нийт 284 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтныг оролцуулсан сэтгүүлчийн аюулгүй байдлын судалгаанд эх сурвалжийн аюулгүй байдлын талаар санаа зовниж нь тодорхой харагдаж байна. Тодруулбал, 64% нь эх сурвалжийн аюулгүй байдлыг хангах чухал байгааг онцолжээ. Мөн 20% нь эх сурвалжаа нууцлах эрх зөрчигдсөн гэж хариулжээ.

⁷ НҮБ-ын Хүний эрхийн хороо. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн талаар гаргасан 34 тоот ерөнхий зөвлөмж. 45 дахь догол мөр. CCPR/C/GC/34 <https://www.refworld.org/docid/4ed34b562.html>

⁸ Европын хүний эрхийн шүүх. Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах талаар гарсан шийдвэрийн тойм. 2021 оны 12 дугаар сар https://www.echr.coe.int/Documents/FS_Journalistic_sources_ENG.pdf

Сэтгүүлчдийг хүний эрхийн хамгаалагч гэж үздэг.⁹ Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д зааснаар хүний эрх хамгаалагч “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явцад олж авсан мэдээллийн эх сурвалжийг тухайн хүний эрхийн зөрчил арилж, эрх нь бүрэн сэргээгдэх хүртэл хугацаанд нууцлах” бүрэн эрхтэй. Гэвч тус хуульд хүний эрх хамгаалагч гэдэгт хамаарах этгээдийг нэрлэн заагаагүй тул тус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах магадлалтай байна. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу ХЭҮК-ын дэргэдэх хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооноос сэтгүүлч Н.Өнөрцэцэгийн ирүүлсэн гомдлын дагуу 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтэд сэтгүүлч Н.Өнөрцэцэгт холбогдох хувь хүний тодорхой үйлдлүүдийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах явцад түүний хамаарал бүхий аж ахуйн нэгж буюу хуулийн этгээд болох Zarig.mn цахим сайтын Монгол Улсаас хандах хандалтыг бүхэлд нь тодорхой хугацаагаар хаасан нь иргэд, олон нийтийн мэдэх эрхийг хязгаарлаж, сэтгүүлчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө ялгаварлан гадуурхалтад өртөх, шүүхээр эцэслэн гэм буруутай нь шийдэгдээгүй байхад гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай мэтээр цахим орчинд нотлогдоогүй сөрөг сэтгэгдлүүдэд өртсөн нь сэтгэл санаа, эрүүл мэндэд нь эрсдэл учруулж болзошгүй байна гэж үзжээ.¹⁰ Энэ жишгээр Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д зааснаар “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явцад олж авсан мэдээллийн эх сурвалжийг тухайн хүний эрхийн зөрчил арилж, эрх нь бүрэн сэргээгдэх хүртэл хугацаанд нууцлах” эрхийг зөрчсөн эсэх асуудлаар тус хороонд хандаж дүгнэлт гаргуулах боломжтой байна. Ийм дүгнэлт нь сэтгүүлчийн эрхийг хамгаалахад нотлох баримт болох ач холбогдолтой юм.

Засгийн газраас Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр УИХ-д өргөн барьсан.¹¹ Энэ хуулийн төслийн 9.9-д “Шүгэл үлээгч эрх бүхий байгууллагад мэдээлэл өгсөн асуудлаар олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болно. Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага нь шүгэл үлээсэн асуудлыг мэдээлсэн эх сурвалжаа нууцлах эрхтэй” гэж заасан.¹² Гэвч дээрх хуулийн төсөлд сэтгүүлч бус зөвхөн олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага нь шүгэл үлээсэн асуудлыг мэдээлсэн эх сурвалжаа нууцлах эрхтэй байх, тэрхүү эх сурвалж нь заавал урьдчилж эрх бүхий байгууллагад мэдээлэл өгсөн буюу шүгэл үлээсэн байх шаардлагатай болж байна. Энэ нь Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд сэтгүүлчдийн эх сурвалжийн нууцлалыг баталгаажуулах шийдлийг оновчгүй тусгасан болохыг харуулж байна. Тус хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын чуулганы 2022.10.20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн.¹³ Хуулийн төслүүдийг хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 59.1 хувь нь дэмжиж, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.¹⁴ Одоогоор энэ хуулийн төслийг УИХ батлаагүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганыг 2024.03.15-ны өдөр нээж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хэлсэн үгэндээ “Шударга бус, ёс зүйгүй

⁹ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газар. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж. 2020 он. 15 дахь тал

<https://www.osce.org/files/f/documents/1/7/454269.pdf>

¹⁰ ХЭҮК-ын дэргэдэх Хүний эрх хамгаалагчийн хороо сэтгүүлч Н.Өнөрцэцэгт холбогдох асуудлаар гаргасан дүгнэлтээ танилцууллаа. 2024.01.05 <https://nhrcm.gov.mn/newsdetail/1867>

¹¹ “Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг өргөн барилаа”. 2021.11.11 <http://www.parliament.mn/n/naaon>

¹² Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 2021.11.11 <http://forum.parliament.mn/projects/11197>

¹³ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэв <https://www.parliament.mn/nn/18721>

¹⁴ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт шилжүүлэв <https://www.parliament.mn/nn/18722>

байдал, хууль завших үзэгдэл, гэмт үйлдлүүдэд олон нийтийн хяналтыг тогтооход чухал ач холбогдолтой Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг энэ чуулганаар батлахад ажлын хэсэг шуурхайлах шаардлагатай” гэж онцлон тэмдэглэсэн.¹⁵ Энэ хүрээнд хуулийн төслийн дээр дурдсан заалтуудыг сайжруулан батлах шаардлагатай байна.

“Сүүлийн жилүүдэд мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах явдал нэмэгдэж, энэ нь хүний эрх, эрх чөлөөнд халдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг үүсгэсэн” гэх үндэслэлээр Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлж, УИХ-аас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр өөрчлөн найруулж баталсан Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйл /Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах/-ийн 1 дэх хэсэгт “Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэх заалт нь гэмт хэргийн асуудлаарх мэдээллийн нууц эх сурвалж ба сэтгүүлчийн хоорондын харилцааг хязгаарлах, хумихад чиглэсэн бөгөөд уг зохицуулалт мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үйл ажиллагааны үндсэн дээр болон шүгэл үлээгчээр дамжуулж буюу мэдээллийн нууц эх сурвалжийн дагуу олж мэдсэн аливаа этгээд, тэр дундаа сэтгүүлчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үр дагавартай болж байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлийн хавсралтад орсон “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын загвар төсөл”-д сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжийг хамгаалах дараах зохицуулалтыг тусгах хувилбар боловсруулжээ:

- *Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр даалгаснаас бусад тохиолдолд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагаас мэдээллийн нууц эх сурвалжийн талаар тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах, түүнийг ил болгохыг шаардахыг хориглох;*
- *Эрүүгийн хэрэгтэй холбоотойгоор сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын нууц эх сурвалжийг дараах шаардлагыг нэг мөр хангаж, шүүхийн шийдвэрээр ил болгох:*
 - *хүний амь нас, эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд бодит хохирол учруулахуйц гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн хэрэгт буруутгуулж буй этгээдийн өмгөөлүүлэх, хэргээ шударгаар шүүлгэх эрхийг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн;*
 - *энд заасан гэмт хэргийг өөр арга замаар нотлох боломжгүй.*
- *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаа, Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан гүйцэтгэх ажлаар сэтгүүлчийн нууц эх сурвалжийг ил болгохыг хориглох.*
- *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг хөндөхөөс сэргийлсэн агуулгатай зүйл, хэсэг нэмэх.*


Энэ хувилбар нь хүний эрхийн олон улсын шүүхүүдийн шийдвэрээр тогтоосон жишгийг тусгасан байх бөгөөд хууль тогтоогчид дээрх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

¹⁵ Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулган эхэллээ <https://www.parliament.mn/nn/52008>

1.4. Мэдээллийн эрх чөлөө ба хязгаарлалт

Улсын Их Хурлын чуулганы 2021.12.17-ны нэгдсэн хуралдаанаар “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн баталсан.¹⁶ 2022.05.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх тус хуульд нийтийн мэдээллийг “нээлттэй”, “хязгаарлалттай”, “хаалттай” гэж ангилсан бөгөөд түүний 7.2-т “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ”, 7.3-т “Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ” гэж, 7.4-т “Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл гэж үзнэ” гэж тус тус заасан.¹⁷ Мөн хуулийн 8 дугаар зүйлд мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээний нийт 67 нээлттэй мэдээллийн жагсаалтыг тусгасан.

Гэвч төрийн мэдээлэл дээд зэргээр ил тод байх, нууцалбал зохих мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашгийн шалгуурт үндэслэн хуулиар тогтоосны үндсэн дээр нууцлах зарчимтай тус хууль нийцэхгүй байна. Тодруулбал, хуулийн 3.1-т “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгоход энэ хууль үйлчлэхгүй”, 7.6-д “Хаалттай, хязгаарлалттай мэдээлэлд хамаарах төрийн болон албаны нууцтай холбогдох Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэх заалтууд нь нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль тогтоомжид Төрийн болон албаны нууцын хуулийг огт хөндөөгүй, улмаар “төрийн нууц”, “албаны нууц” нэрийн дор олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлыг үл хайхран мэдээллийг нууцлах, мэдээлэл өгөхгүй байх, төрийн байгууллага, албан тушаалтны алдаа, дутагдлыг нуух, хаацайлах өнөөгийн байдлыг залруулахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үр дүнгүй байх шинжтэй байна.¹⁸



Дээрх бүдүүвчид харуулснаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийн тоо 67, хаалттай мэдээлэл буюу Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт” дахь мэдээлэл 572 байна. Харин төрийн нууцад хамаарах мэдээллээс 3 дахин их мэдээлэл албаны нууцад хамаарч байгааг харгалзан хязгаарлалттай мэдээллийн тоог 1716 гэж тооцов.¹⁹

¹⁶ “Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулиудыг эцэслэн баталж, эцсийн найруулга сонслоо”. 2021.12.17 <http://www.parliament.mn/n/5eaon>

¹⁷ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2022 он

¹⁸ Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын дэргэдэх “Засаглалд залуу сэтгүүлчдийн оролцоо хөтөлбөр”-ийн төгсөгчдийн холбоотой хамтран 2021.10.19-ний өдөр хэвлэл мэдээллийн салбарын эвсэл, холбоод, мэргэжлийн байгууллагын төлөөллийн оролцоотой зохион байгуулсан хэлэлцүүлгээс гарсан саналын дагуу УИХ-ын нэр бүхий гишүүдэд хүргүүлсэн санал. 2021.10.26 <https://www.mediacouncil.mn/a/310>

¹⁹ Тухайлбал, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд төрийн нууцад хамааруулах мэдээллийн тоо 17 бол, түүний албаны нууцад хамаарах мэдээллийн тоо 52 байна.

Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар. “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ”. Улаанбаатар. 2019 он. 43 дахь тал

Глоб интернэшнл төвөөс Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр 2022 оны 5-10 дугаар сарыг хамруулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд мониторинг хийсэн.²⁰ Энэ хүрээнд Баян-Өлгий, Орхон, Хөвсгөл, Ховд аймаг, Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн мэдээлэл хариуцагчийг сонгож хуульд заасан нээлттэй мэдээллийг нийтэлж ил болгосон байдал, мэдээлэл авах хүсэлтэд хариу өгсөн байдлыг үнэлж, хувиар илэрхийлсэн.

Хүснэгт 1. Мэдээлэл авах хүсэлт гаргахаас өмнө мэдээллийг ил болгосон байдлыг үнэлэх хүснэгт

| Нээлттэй мэдээллийн төрөл, түүний мэдээлэл | Нээлттэй мэдээллийн нийтлэгдсэн байдал | | | | | Мэдээллийн эх сурвалж (цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл) |
|------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|---------------------------|-------------------|-----------------------------|---------|------------------------------------------------------------------------------------|
| | Бүрэн (100%) | Бүрнээс хэсэгчилсэн (75%) | Хэсэгчилсэн (50%) | Хэсэгчилснээс байхгүй (25%) | Байхгүй | |
| 1/ Мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл /10/ | | | | | | |
| 2/ Мэдээлэл хариуцагчийн хүний нөөцийн талаарх мэдээлэл /6/ | | | | | | |
| 3/ Мэдээлэл хариуцагчийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл /27-13/ | | | | | | |
| 4/ Мэдээлэл хариуцагчийн хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл /2/ | | | | | | |
| 5/ Мэдээлэл хариуцагчийн эрхлэх асуудлын хүрээний мэдээлэл /21-9/ | | | | | | |

Хууль хэрэгжиж эхэлсэн эхний гурван сарын хугацаанд нэр бүхий мэдээлэл хариуцагчдын хувьд мэдээллийг ил тод болгосон байдал дунджаар 43.3%-тай байна.

Хүснэгт 2. 2022 оны 5-7 дугаар сард зарим аймаг дахь мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийг ил болгосон байдал

| | | | | | |
|-------------------------------|---------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|--------------------------------|----------------------------------------|
| Сонгинохайрхан дүүрэг /13.7%/ | Газрын алба: 7.3% | МҮОНРТ: 4.5% | ЗДТГ: 29.5% | | |
| Баян-Өлгий аймаг /38.5%/ | 2-р сургууль: 38.6% | Онцгой байдлын газар: 50.5% | Монгол банк: 40.3% | Цагдаагийн газар: 31.2% | 22-р цэцэрлэг: 32.3% |
| Орхон аймаг /82.4%/ | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар: 73.8% | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ: 92.5% | ЗДТГ: 81% | | |
| Хөвсгөл аймаг /61.2%/ | ЗДТГ: 61.2% | | | | |
| Ховд аймаг /20.7%/ | Бүсийн оношилгоо, эмчилгээний төв: 15.3% | ЗДТГ: 26.1% | “Жаргалан” өрхийн ЭМТ: 8.5% | Мэргэжлийн хяналтын газар: 21% | Боловсрол, шинжлэх ухааны газар: 40.3% |

Харин хууль хэрэгжиж эхэлсэн 4-6 дугаар сарын хувьд нэр бүхий мэдээлэл хариуцагчдын хувьд мэдээллийг ил тод болгосон байдал дунджаар 45.4%-тай байна.

Хүснэгт 3. 2022 оны 8-10 дугаар сард зарим аймаг дахь мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийг ил болгосон байдал

²⁰ Глоб интернэшнл төв. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн мониторингийн явц. 2022 <https://gic.mn/post/r/1689>

| | | | | | |
|--------------------------|----------------------------------------------|----------------------------------------------------------|-------------------------------------|-----------------------|----------------------------------|
| Улаанбаатар /55.8%/ | БЗД-ийн Хөгжлийн төв ОНӨҮГ – 19.5% | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв – 38.1% | Мал эмнэлгийн ерөнхий газар – 51.1% | ХААХҮЯ – 75.6% | Ус сувгийн удирдах газар – 94.7% |
| Баян-Өлгий аймаг /23.2%/ | Боловсрол, соёл урлагийн газар – 8.8% | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар – 12.7% | ХЭҮК-ын салбар – 25.3% | Нэгдсэн эмнэлэг – 46% | |
| Орхон аймаг /68.9%/ | Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс – 57.8% | Боловсрол, соёл урлагийн газар – 72.6% | Татварын хэлтэс – 76.2% | | |
| Хөвсгөл аймаг /43.5%/ | Мөрөн сумын ЗДТГ – 43.2% | Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төв – 43.8% | | | |
| Ховд аймаг /35.6%/ | Цаст Алтай сургууль – 21.6% | “Шинэ Ховд” бизнес хөгжлийн төв – 24.5% | ЗДТГ – 41% | 16-р цэцэрлэг – 55.5% | |

Хууль хэрэгжиж эхэлсэн эхний гурван сарын хугацаанд дээрх сонгосон бүс нутаг дахь нэр бүхий мэдээлэл хариуцагчдын хувьд мэдээлэл авах хүсэлтийн дагуу мэдээлэл өгсөн байдал 30.4%-тай байна. Хууль хэрэгжиж эхэлсэн 4-6 дугаар сарын хугацаанд нэр бүхий мэдээлэл хариуцагчдын хувьд мэдээлэл авах хүсэлтийн дагуу мэдээлэл өгсөн байдал 42.5%-тай байна.

Хүснэгт 4. 2022 оны 5-7 дугаар сард зарим аймаг дахь мэдээлэл авах хүсэлтэд хариу өгсөн байдал

| Мэдээлэл хариуцагч | Огноо | | Мэдээлэл өгсөн эсэх /нийт 23 хүсэлт/ | | | |
|---------------------------------------------------------------------|------------|-------------|--------------------------------------|-------------|----------------|----------------|
| | Хандсан | Хариу өгсөн | Шилжүүлсэн: 1 | Өгөөгүй: 14 | Бүрэн өгсөн: 7 | Дутуу өгсөн: 1 |
| Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар | - | 2022.08.22 | | | + | |
| Баян-Өлгий аймгийн Прокурорын газар | - | - | | | + | |
| Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар | 2022.08.03 | - | | | | + |
| Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар | - | 2022.08.20 | | | + | |
| МҮОНРТ | 2022.07.18 | - | | + | | |
| Орхон аймгийн БОЭТ | 2022.07.27 | - | | + | | |
| Орхон аймгийн ЗДТГ | 2022.07.27 | - | | + | | |
| Орхон аймгийн МАН-ын хороо | 2022.07.27 | - | | + | | |
| Орхон аймгийн Найдвар төв ТББ | 2022.07.27 | 2022.07.29 | | | + | |
| СХД-ийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл, сургалтын төв ОНӨҮГ | 2022.07.18 | 2022.07.20 | | | + | |
| СХД-ийн ЗДТГ-ын ТЗУХ | 2022.07.18 | - | | + | | |

| | | | | | | |
|------------------------------------------------------------------|------------|------------|---|---|---|--|
| СХД-ийн ЗДТГ-ын Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт шинжилгээний хэлтэс | 2022.07.18 | - | | + | | |
| СХД-ийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | 2022.07.18 | 2022.07.26 | | | + | |
| СХД-ийн ЗДТГ-ын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс | 2022.07.18 | - | | + | | |
| СХД-ийн Төхижилт, цэвэрлэгээ үйлчилгээний хэлтэс ОНӨААТҮГ | 2022.07.18 | - | | + | | |
| СХД-ийн Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ | 2022.07.18 | - | | + | | |
| Ховд аймгийн ЗДТГ-ын Архивын тасаг | 2022.06.25 | - | | + | | |
| Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар | 2022.07.21 | 2022.07.25 | + | | | |
| Ховд аймгийн “Жаргалан” өрхийн эрүүл мэндийн төв | 2022.06.24 | - | | + | | |
| Ховд аймгийн АН-ын хороо | 2022.06.24 | - | | + | | |
| Хөвсгөл аймгийн АН-ын хороо | 2022.07.19 | 2022.07.28 | | | + | |
| ХҮН-ын ЕНБД | 2022.07.18 | - | | + | | |
| Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | 2022.07.27 | - | | + | | |

Хүснэгт 5. 2022 оны 8-10 дугаар сард зарим аймаг дахь мэдээлэл авах хүсэлтэд хариу өгсөн байдал

| Мэдээлэл хариуцагч | Огноо | | Мэдээлэл өгсөн эсэх /нийт 27 хүсэлт/ | | | |
|----------------------------------------------------------|------------|------------|--------------------------------------|---------|-------|-------|
| | Хандсан | Хариу | Шилжүүлсэн | Өгөөгүй | Өгсөн | Дутуу |
| Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар | - | - | - | - | 1 | - |
| Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 5 дугаар сургууль | - | - | - | 1 | - | - |
| Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газар | - | - | - | 1 | - | - |
| Баян-Өлгий аймгийн Гэр бүл, ХЗХ-ийн газар | - | - | - | - | 1 | - |
| Баян-Өлгий аймгийн Бугат сумын засаг дарга | - | - | - | - | 1 | - |
| Баян-Өлгий аймгийн Татварын хэлтэс | - | - | - | - | 1 | - |
| Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар | - | - | - | 1 | - | - |
| Баян-Өлгий аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар | - | - | - | 1 | - | - |
| Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар | - | - | - | - | 1 | - |
| Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ | 2022.10.14 | - | - | 1 | - | - |
| Орхон аймгийн Музей | 2022.10.14 | 2022.10.18 | - | - | 1 | - |
| Орхон аймгийн Аудитын газар | 2022.10.14 | - | - | 1 | - | - |

3.2.4-т “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.6-д заасны дагуу Засгийн газраас баталсан жагсаалтад заасан хугацаанд шинэчлэгддэг байх” гэсэн нь хуулийн 12.4-т “Мэдээлэл хариуцагч өөрийн боловсруулсан нээлттэй өгөгдлийг тогтмол шинэчилж байна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Засгийн газрын 2022.05.18-ны өдрийн 202 дугаар тогтоолын хавсралт “Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал”-ын 2.1-т зааснаар нээлттэй өгөгдлийг бий болгосон ажилтны ажлын цагийн хөлс, нээлттэй өгөгдлийг боловсруулж гаргахад зарцуулсан гүйцэтгэлийн хугацааг тодорхойлох мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдлийн төлбөрийг тооцно. Энэ нь хуулийн 16.1-д “Хүн, хуулийн этгээд цаасан хэлбэрээр мэдээлэл авахдаа хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл өгөхтэй холбогдон гарсан зардлыг төлнө”, 16.2-т “Энэ хуулийн 16.1-д заасан зардал нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас ихгүй байна” гэснийг зөрчиж байна. Мөн журмын 3.3-т “Мэдээлэл хариуцагч хүн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн нээлттэй өгөгдлийг боловсруулж өгөх хугацаа 30 хоногоос илүүгүй байна” гэсэн нь хуулийн хуулийн 15.6.1, 15.6.2, 15.7-д заасан хугацааны нөхцөлийг зөрчиж байна.

Засгийн газрын 2022.05.31-ний өдрийн 211 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хязгаарлалттай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журам”-д заасан мэдээллийн эзэнд хүргэх мэдэгдлийн маягтад заасан мэдээлэл авсан үндэслэл (хуульд заасан, эсхүл мэдээллийн эзэн зөвшөөрсөн) болон дамжуулсан мэдээллийг практикт хүргүүлэхгүй байна. Цаашид e-mongolia.mn дэх “Мэдэгдэл хүргэх систем”-ээр иргэний мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан талаар бүрэн мэдээлэл өгч байх шаардлагатай байна.

“Бодлогод залуусын хяналт” НҮТББ-аас “Судалгаа хийх зорилгоор Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын эцсийн тайланг бүрэн эхээр нь авах хүсэлтийг Үндэсний Аудитын газарт гаргасан боловч холбогдох хуулиудыг буруу тайлбарлан, нийтэд нээлттэй байлгах мэдээллийг гаргаж өгөхөөс удаа дараа татгалзаж, олон нийтийн мэдэх эрхийг зөрчсөн” гэх гомдлыг Хүний эрхийн Үндэсний Комисст 2022.10.14-ний өдөр гаргажээ. Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-д “Сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан”, “Сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн зарлагын дэлгэрэнгүй тайлан” маягтад тусгагдсаны дагуу бүрэн өгөөгүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 17 дахь заалт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар баталгаажуулсан хүний мэдээлэл авах эрхийг зөрчсөн гэж үзэж Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023.01.17-ны өдөр Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбатад шаардлага хүргүүлсэн. Энэ шаардлагын дагуу 2023.03.15-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн орлого, зардлын тайланд холбогдох 7 боть бүхий 1666 хуудас материал, Монгол Улсын Их Хурлын 2020 оны сонгуулийн орлого, зардлын тайланд холбогдох 98 боть бүхий 22172 хуудас материалыг Үндэсний аудитын газраас “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-д хүлээлгэн өгсөн. Ингэхдээ эдгээр материалыг Үндэсний аудитын газар өөрийн цахим хуудаастаа байршуулаагүй, зөвхөн нэг байгууллагад хүлээлгэн өгсөн нь сонгуулийн зардлын дэлгэрэнгүй тайлангийн мэдээллийн хүртээмжийг хязгаарлаж байна. ХЭҮК-оос холбогдох шаардлагадаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.22-т “хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл”-ийг мэдээлэл хариуцагч байнга ил тод, нээлттэй байлгах зохицуулалтыг баримталсан байх бөгөөд энэ нь нийтийн мэдээллийн жагсаалтыг өргөжүүлж, иргэдэд нээлттэй мэдээллийн нэгдсэн жагсаалт бий болгох шаардлагатай болохыг харуулж байна. Түүнчлэн нээлттэй байх ёстой мэдээллийг олж авах үйл явц ямар хүндрэл, бэрхшээлтэй туулж байгааг дээрх үйл явдлаас тодорхой харж болохоор байна.

1.5. Сонгууль ба хэвлэл мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэхдээ дараах хэсэгт өөрчлөлт оруулсан. Үүнд:

- (14.13) Сонгуулийн ерөнхий хорооноос санал хураалтын дүнгийн талаар албан ёсны мэдээлэл гаргаагүй байхад аливаа этгээд санал хураалтын дүнгийн талаар мэдэгдэл хийхийг хориглоно. Үүнийг зөрчвөл Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1-т заасны дагуу хүнийг 10 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 100 сая төгрөгөөр торгоно.
- (39.5) Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлнэ. Үүнийг зөрчвөл Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 8-д заасны дагуу хуулийн этгээдийг 20 сая төгрөгөөр торгоно.
- (46.2) Олон нийтийн радио, телевиз сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлнэ.
- (46.4) Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзэж, сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн хуваарь, цагийг тэнцүү байхаар тооцож сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө батална.
- Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг (46.9.1) сурталчилгааны нэвтрүүлэг явуулахаар төлөвлөсөн цагийн хуваарь, (46.9.3) сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх үнийн саналын хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, бүртгүүлнэ.
- (46.11) Радио, телевиз нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг аль нэг сувгаар нэвтрүүлнэ.
- (46.17) Улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн төлөөлөл оролцсон байна.
- (46.20) Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмыг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн, энэ хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хороо батална.
- Аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор (48.1.7) хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэхийг хориглоно.
- (48.9) Нам, эвслийн дарга, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орох, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч ухуулах байр ажиллуулахыг хориглоно. Үүнийг зөрчвөл Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 20-д заасны дагуу хүнийг 20 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 сая төгрөгөөр торгоно.
- (48.12) Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуулийн 48.9, 48.10-д заасан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах бөгөөд энэ хуулийн 48.8, 48.9, 48.10-д заасныг зөрчсөн тохиолдолд радио, телевизийн байгууллагын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар хязгаарлана.

Мөн дараах хэсгийг нэмсэн. Үүнд:

- (39.7) Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевиз нь энэ хуулийн 39.5-д заасны дагуу нийтэд мэдээлсэн тайланг шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нийтэд мэдээлснээс хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.
- (46.3) Олон нийтийн радио, телевиз нь нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг олгох саналаа Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэхдээ нам, эвслээс нэр дэвшигчдэд намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, эвслийн тухайд эвсэлд нэгдэн орсон намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, бие даан нэр дэвшигчийн тухайд Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн дарааллыг баримтлан ижил нөхцөл, тэнцүү хугацаа ногдохоор тооцно.
- (46.27) Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно.
- (46.28) Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.
- (47.12) Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаалын хавсралтаар “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ”-г баталсан.²² Тухайлбал, 1 дүгээр тойрогт зардлын дээд хэмжээ 1,379.0 сая төгрөг байна. Ингэснээр тус тойрогт нэг нэр дэвшигчийн зүгээс цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал 206,850,000 төгрөг хүртэл байна.
- (48.10) Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.
- (48.16) Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуулийн 48.15-д заасан дүгнэлтийг үндэслэн тухайн телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг дүгнэлтэд дурдсан хугацаагаар хязгаарлах арга хэмжээг авна.
- (67.19) Сонгогчийг санал өгсний дараа өгсөн саналынх нь талаар асуухыг хориглоно.
- (71.16) Хяналтын тооллого хийх ажиллагаанд ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын болон сонгогчдын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно.
- (72¹.2) Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22:00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 15-д эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол хүнийг 5 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 50 сая төгрөгөөр торгохоор заасан. Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан. Энэ журам дараах онцлог зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- (2.4) Хиймэл оюун ухаан ашиглан бүтээсэн сонгуулийн сурталчилгаа, сонгуультай холбоотой мэдээлэл бүхий зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгт "Хиймэл оюун ухаан ашиглан бүтээсэн" гэх таних тэмдгийг харагдахуйц байдлаар байрлуулах бөгөөд таних тэмдгийг байрлуулаагүй тохиолдолд уг контентыг устгах, эсхүл хандалтыг хаах, эсхүл түр хязгаарлах арга хэмжээ авна.

²² Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох тухай Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал <https://audit.mn/?p=24779>

- (1.4) “Цахим орчны үйлчилгээ эрхлэгч” гэдэгт цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контентыг олон нийтэд хүргэх этгээдийг ойлгоно гэж тодорхойлсон бөгөөд (3.2) Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3-т заасан бусад цахим хуудас нь сонгуулийн сурталчилгаа нийтлэх тохиолдолд сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан Цахим орчны үйлчилгээ эрхлэгчээс сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн маягтын дагуу бүртгүүлнэ.
- Цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь (5.2.4) сонгуулийн сурталчилгаа хийсэн тохиолдолд сонгуулийн сурталчилгааг захиалсан этгээд болон сонгуулийн сурталчилгааны төлбөрийн талаарх мэдээлэл агуулсан тайланг сонгуулийн санал хураах өдрийн дараа өдрөөс хойш 30 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан Сонгуулийн сурталчилгаа явуулсан тайлангийн загварын дагуу бэлтгэж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй бөгөөд (5.2.5) домэйн нэр ашиглан мэдээ мэдээллийг хэрэглэгчид хүргэж буй бүх төрлийн вэб сайт нь сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтлэх, (7.2) иргэн, хуулийн этгээдийн гомдол маргааныг хүлээж авах шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаягийг олон нийтэд ил тод байршуулах үүрэгтэй. Мөн (7.4) Цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч нь хүн, хуулийн этгээдийн гомдол, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайланг сонгуулийн сурталчилгааны хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор гаргаж, олон нийтэд нээлтэй мэдээлнэ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11-т “Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно” гэж заасан. Гэхдээ Сонгуулийн ерөнхий хорооны саналд тавигдах шаардлага, түүний агуулгын талаар хууль, журамд тусгайлан заагаагүй нь цахим орчин дахь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдэх эрхийг хэтрүүлэн хязгаарлах эрсдэлийг бий болгож байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.24-т “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх талаар энэ хуулийн 46.20-д заасан журам зөрчсөн бол эхний удаад сануулах арга хэмжээ авах, эсхүл радио, телевизийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхийг санал авах өдөр хүртэл цуцлах тухай шийдвэр гаргана” гэж заасан бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам” шинэчлэн баталсан.

Мөн хуулийн 46.25-д зааснаар Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэхгүйгээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол тухайн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгоно. Мөн 46.26-д зааснаар сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг /60 минут/-аас илүүгүй байх, түүний хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдох, сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн оролцсон сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлага гаргахгүй байх үүргийг зөрчсөн бол телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгоно.

Энэ нь хууль, журамд заасан зөрчил гаргасан телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгох ба Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 12-т зааснаар “Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн бол” хуулийн этгээдийг 100 сая төгрөгөөр торгох, 20-д зааснаар “...сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн,

нийтэлсэн бол” хүнийг 20 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 сая төгрөгөөр давхардуулан торгох эсэх, телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулах, өндөр үнийн дүнгээр торгуулах арга хэмжээний аль нэгийг сонгох боломжтой эсэхэд эргэлзээ бий болгож байна. Аль ч тохиолдолд телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зүгээс сонгуулийн хуулийг ягштал мөрдөөгүй тохиолдолд эдийн засгийн цензур тогтоох үр дагавартай байна.

1.6. Нэр төр гутаахтай холбоотой зохицуулалт

Засгийн газраас 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2-т зааснаар, Эрүүгийн хуульд “13.15 дугаар зүйл.Доромжлох” гэмт хэргийг нэмж “1. Хүний нэр төр, алдар хүндийг олон нийтэд гутаан доромжилсон бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж тусгажээ.

Эрүүгийн хуульд гүтгэх, доромжлох гэмт хэргийг тусгах нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэтрүүлэн хязгаарлах, сэтгүүл зүйн үйл ажиллагаанд цензур тогтоох үр дагавартай болохыг хүний эрхийн олон улсын байгууллагууд буюу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний байгууллагуудын зүгээс онцгойлон анхааруулсан байдаг. Тодруулбал, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2015 онд Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний II илтгэлийг хэлэлцэж өгсөн 150 зөвлөмжийг манай улс хэрэгжүүлэх үүрэг амлалт авч, Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг баталсан бөгөөд уг төлөвлөгөөнд гүтгэх, доромжлох үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохоо болих асуудлыг судалж шийдвэрлэхээр заасан. Улмаар Улсын Их Хурлаас 2015 онд баталсан, 2017 оноос үйлчилсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад доромжлох, гүтгэх үйлдлийг хасаж хуульчилсан.

Гэвч “жигжиг гэмт хэргийн хууль” гэгддэг Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд “Гүтгэх” зөрчлийг хуульчилсан, 2020.01.10-ны өдөр Зөрчлийн тухай хуулиас “Гүтгэх” зөрчлийг хасч, Эрүүгийн хуульд “13.14 дүгээр зүйл.Худал мэдээлэл тараах” гэж нэрлэн нэмсэн. Үүнтэй холбоотойгоор 2020.11.04-ний өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн Ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр өгсөн зөвлөмжид “Гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх арга хэмжээ авах замаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд ямарваа шийтгэл хүлээхээс айж эмээх зүйлгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын стандартын дагуу чөлөөтэй явуулах нөхцөлийг хангах” гэж заасан.²³ Үүнийг баталгаажуулж НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2021.03.16-ны өдрийн 46/105 тоот тогтоол гарсан.²⁴

Түүнчлэн, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын төрөлжсөн байгууллага буюу ЮНЕСКО-гийн “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээллийн хөгжлийн дэлхийн чиг хандлага”-ын тайланд “Гүтгэх, доромжлох үйлдлийг эрүүжүүлэх замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах явдал дэлхий даяар нэмэгдэж байна. Гүтгэх, доромжлохтой холбоотой асуудлыг шүүхийн бус журмаар буюу хэвлэлийн зөвлөл зэрэг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын механизмаар шийдвэрлэх нь зүйтэй байна” гэж дүгнэсэн.²⁵

Иймд “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг Эрүүгийн хуульд оруулсан, доромжлох үйлдлийг дахин гэмт хэрэгт тооцож зүйлчлэхээр хэлэлцэж байгаа нь өмнөх олон улсын үүрэг амлалт, байр сууриас ухарсан алхам болох тул дээрх “доромжлох” гэмт хэргийг

²³ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн Ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр өгсөн зөвлөмж

https://www.upr-mongolia.mn/images/UPR-Recommendations_MON_2022.pdf
<https://www.ohchr.org/en/hr-bodies/upr/mn-index> <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G21/045/64/PDF/G2104564.pdf?OpenElement>

²⁴ A/HRC/DEC/46/105 <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G21/071/60/PDF/G2107160.pdf?OpenElement>

²⁵ UNESCO. The “misuse” of the judicial system to attack freedom of expression: trends, challenges and responses. 2022 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000383832>

Эрүүгийн хуульд нэмэхгүй байх, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийг хүчингүй болгох шаардлагатай байна.

Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд орсон “доромжлох” гэмт хэрэгтэй холбоотойгоор иргэний нийгмийн байгууллагаас гадна Гадаад харилцааны яамны 2022.04.14-ний өдрийн 09/1777 тоот албан бичиг, Хууль зүйн туслалцааны төвийн 2022.04.12-ын өдрийн 1/112 тоот албан бичигтээ “доромжлох” гэмт хэргийн зохицуулалтыг хуулийн төслөөс хасах талаар Засгийн газарт санал өгч байжээ. Гэвч эдгээр байгууллагын саналыг үл хэрэгсэж Засгийн газраас дээрх хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн явдал нь “доромжлох” гэмт хэргээр дамжуулан Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх явдлыг зориуд хясан боогдуулах санаа, зорилготой гэж үзэхэд хүргэж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газар санаачилж, өргөн мэдүүлэхдээ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Эрүүгийн хуульд зарим гэмт хэргийг шинээр тусгах, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн улмаас үүсэх гэм хорыг бууруулах чиглэлээр холбогдох өөрчлөлтийг тусгах, хуулиар харьяалуулсан зарим гэмт хэргийн шинжийг Зөрчлийн хуульд заасан зөрчлийн шинжээс ялгаатай байдлаар хуульчлах, нийгмийн хор аюул, үйлдэгдэж байгаа арга, хэлбэрээс хамаарч зарим гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг оновчтой болгох”-оор тусгасан. Гэвч энэ тогтоолыг зөрчиж, “доромжлох” үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор Засгийн газраас зүтгэж байна.

Эрүүгийн хуульд гүтгэлэг, доромжлолтой холбоотой зохицуулалтыг оруулахгүй байх замаар шүүмжлэлт, эрүүл дуу хоолой, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалах нь зүйтэй байна. Энэ нь бусдыг гүтгэх, доромжлох явдлыг зөвтгөөгүй бөгөөд энэ асуудлыг Иргэний хуулийн зохицуулалтын дагуу иргэний хэргийн шүүхээр болон хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагаар шийдвэрлүүлэх арга зам нь илүү тохиромжтой болно.

Дээрх НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн зөвлөмж гарснаас хойш 3 жилийн дараа буюу Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 357 дугаар тогтоолын хавсралтаар “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө” баталсан. Энэ төлөвлөгөөнд “116.69.Гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх арга хэмжээ авах зэрэг замаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд ямарваа шийтгэл хүлээхээс айж эмээх зүйлгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын стандартын дагуу чөлөөтэй явуулах нөхцөлийг хангах” зөвлөмжийн дагуу “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)-ийг боловсруулах”, “116.71.Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагыг хараат бусаар мөрдөн шалгах нөхцөлийг баталгаажуулж, гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд шийтгэл хүлээлгэх” зөвлөмжийн дагуу “Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны эсрэг үйлдсэн халдлагыг мөрдөн шалгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулах, халдлагыг мөрдөн шалгах үйл ажиллагааг бэхжүүлэх” арга хэмжээ авахаар тус тус заасан. Энэ төлөвлөгөөний заалт нь Эрүүгийн хуулиас гүтгэх гэмт хэргийг хасах, доромжлох гэмт хэргийг нэмэхгүй байх агуулгыг илэрхийлэхгүй юм.

Үүнээс гадна Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл (Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах)-ийн 1-т “Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл (Сонгуулийн хуулийг зөрчих)-ийн 7-д “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр

торгоно” гэж тус тус заасан. Эдгээр зохицуулалт нь сонгуулийн үеэр сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн талаар чөлөөтэй хэлэлцэх, шүүмжлэх боломжийг хязгаарлаж, цензур тогтоосон шинжтэй байна.

Зөрчлийн тухай хуулийн 5.20 дугаар зүйл (Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих)-ийн 2-т “Хүний эрх хамгаалагч нь ... хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны явцад бэлтгэсэн, нийтэлсэн мэдээ, нийтлэлд эрх ашиг нь хөндөгдсөн этгээдийн гомдлоор сэтгүүлчийг торгох, хохирол, нөхөн төлбөрийн буюу эдийн засгийн цензур тогтоох үр дагавартай байна. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 2022.11.10-ны өдрийн дүгнэлтэд “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд эрх мэдэлтнүүд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд саад учруулах, хязгаарлахад ашиглах заалтууд тусгасан байна. Тухайлбал, 8.1.3-т хүний эрх хамгаалагчид хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаахыг хориглосон заалт” гэжээ.²⁶ НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн Монгол Улсад хийсэн айлчлалын 2023.07.05-ны тайлангийн 23-т “Хүний эрх хамгаалагчид хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаахыг хориглоно гэсэн заалтуудад Ажлын хэсэг санаа зовж байна. Хүний эрх хамгаалагчдын хууль ёсны ажил нь одоо байгаа бодлого, үйл ажиллагааг шүүмжлэх, эсэргүүцэх явдал байдгийг дурдахад ийм бүдэг бадаг, өргөн хүрээтэй үг хэллэг, ялангуяа “нэр хүнд” гэсэн нэр томъёог буруугаар ашиглаж, тэдний ажлыг “дуугүй” болгож, гэмт хэрэгт тооцоход хүргэж болох”, 24-т “Тодорхой бус, өргөн утгаар томъёолсон хуулийн заалтууд нь lex certa зарчмыг зөрчихөд хүргэж болзошгүй бөгөөд энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 11 дүгээр зүйлийн 2-т заасан хууль ёсны зарчмаар тогтоогдсон хуулийн зохих процессыг зөрчиж болно. Хууль ёсны зарчмын урьдчилсан нөхцөлийг хангасан хууль зүйн үндэслэлгүйгээр хүний эрх чөлөөг хасахад тодорхой бус үг хэллэг бүхий заалтыг ашиглаж болно” гэж онцлон шүүмжилжээ.²⁷ Иймд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8, 8 дугаар зүйлийн 8.1.3, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг, үүнтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хуулийн 5.20 дугаар зүйл /Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих/-ийн 2 дахь хэсгийн “...хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан” гэснийг тус тус хүчингүй болгох шаардлагатай байна.

Дээр дурдсан заалтуудаас гадна Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйл (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих)-ийн 1-т “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1.1-т иргэн “бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах, гэмт хэрэг, зөрчилд бусдыг өдөөн хатгахгүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг гажуудуулах үйлдэл гаргахгүй байх” үүрэгтэй гэж тус тус заасан. Энэ нь практикт Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн дээр дурдсан бусад заалтаар шийтгэх боломжгүй үед хэрэглэгддэг заалт болж, иргэдийн шүүмжлэлт дуу хоолойг хязгаарлах үр дагавартай болжээ.

²⁶ UN, Committee on Economic, Social and Cultural Rights. Concluding observations on the fifth periodic report of Mongolia. E/C.12/MNG/CO/5 (CESCR 2022)

<https://undocs.org/Home/Mobile?FinalSymbol=E%2FC.12%2FMNG%2FCO%2F5&Language=E&DeviceType=Desktop&LangRequested=False>

²⁷ UN, Human Rights Council. Visit to Mongolia. Report of the Working Group on Arbitrary Detention. A/HRC/54/51/Add.2

<https://undocs.org/Home/Mobile?FinalSymbol=A%2FHRC%2F54%2F51%2FADD.2&Language=E&DeviceType=Desktop&LangRequested=False>

1.7. Агуулгын хязгаарлалт

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэхгүйгээр 2023.01.18-ны өдөр Ерөнхий сайд Н.Оюун-Эрдэнийн “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай” албан бичгээр УИХ-ын даргад хандаж Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлж, УИХ-ын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүссэн. Засгийн газраас өргөн барьсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлын тов, дараалал харгалзахгүйгээр УИХ-ын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр тогтсон. Ингээд 2023.01.20-ны өдөр буюу 2 өдрийн дотор Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг эцэслэн батлах саналын томьёоллоор санал хураахад, хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь дэмжсэн. Мөн уг хуультай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг баталж, эцсийн найруулгыг нь сонссон.²⁸

Үүнээс хойш 2023.01.27-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх тус хуульд бүхэлд нь хориг тавих талаар Ерөнхийлөгчийн тамгын газраас мэдээлсэн бөгөөд 2023.01.30-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хоригийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн бөгөөд Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь хориг тавьсан үндэслэлээ “Хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах үйл явцад иргэн, олон нийтийн оролцоог хангаагүй, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагаар хэлэлцүүлж, саналыг аваагүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.”, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6 дахь заалт, 38 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, ... үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байна” гэж тайлбарлажээ.²⁹ УИХ-аас Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч, 2023.03.30-ны өдөр Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хүчингүй болгосон.

Гэхдээ Ерөнхийлөгчийн хориг болон УИХ-ын шийдвэрт дээрх хуулиудын зохицуулалт буруу байсан эсэх талаар байр суурь илэрхийлээгүй. Олон нийтийн сүлжээн дэх контент нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д баталгаажсан үзэл бодлоо цахим орчинд илэрхийлж буй хэлбэр юм. Иймд цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хууль бусаар, хэтрүүлэн хязгаарлах үр дагавартай хуулийн төслийг батлах нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т заасан төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг зөрчих нөхцөл бүрдэнэ. Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан гэмт хэрэг, зөрчилд хамаарах агуулгыг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.12-т “зөрчилтэй контент” гэж нэрлэж, түүнийг хэрэг хянан шалган шийдвэрлэх хууль тогтоомжид зааснаас өөр журмаар, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу яамны харьяа байгууллагаас хянан шийдвэрлэхээр тусгасан нь хууль дээдлэх, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болох зарчмыг алдагдуулсан. НҮБ-ын Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалах, дэмжих

²⁸ Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулган өндөрлөлөө <https://www.parliament.mn/nn/29422/>

²⁹ Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх нэр бүхий хуулиудад бүхэлд нь хориг тавив <https://president.mn/25642/>

асуудлаарх Тусгай илтгэгчийн “Улс орнууд зөвхөн хууль ёсны байх, зайлшгүй шаардлагатай байх, арга зам нь тохиромжтой байх хэм хэмжээний дагуу хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийн байгууллагын шийдвэр, захирамжийн дагуу контентыг хязгаарлаж болно” гэж онцолсон бөгөөд дээрх хуулийн төсөл хүний цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчилтэй контенттой тэмцэх нэрийн дор зүй бусаар хязгаарлах эрсдэлтэй байв.³⁰ Үүнээс гадна онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд халдсан кибер халдлага гарч болзошгүй гэх нөхцөлд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тэргүүний ахалсан Кибер аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрээр зөрчилтэй контентын тархцыг бууруулах, харилцаа холбооны сүлжээг хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэх зохицуулалт нь Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах үүрэгт хамааралгүй бөгөөд “болзошгүй” гэх нэрийн дор НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2016 онд A/RES/71/199 тогтоолдоо “интернэттэй байх нь хүний эрх” гэж заасныг зөрчих үр дагавартай байв. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хууль, тогтоолын төслийг нэн яаралтай хэлэлцэхээр заасан бөгөөд “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах” тухай хуулийн төсөл, түүний дагалдах хуулийн төслүүд нь ийнхүү нэн яаралтай хэлэлцэх хуулийн төсөлд хамаарахгүй юм.

³⁰ U.N. DOC/A/HRC/38/35, para. 66. <https://documents-dds-ny.un.org/doc/UNDпOC/GEN/G18/096/72/PDF/G1809672.pdf?OpenElement>

1.8. Бусад зохицуулалт

Зөрчлийн тухай хуульд 14.15 дугаар зүйл буюу “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих” зөрчлийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн. Үүний дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлгийг бэлтгэх, нэвтрүүлэх, дамжуулах техник, тоног төхөөрөмжийн сүлжээний найдвартай ажиллагаа, стандартын шаардлагыг хангаагүй бол нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлд зааснаас бусад төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ, байршилд эрхэлсэн бол хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхийг хориглосон этгээд эрхэлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тусгасан. Гэвч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.50-д заасан харилцаа холбооны хяналтын улсын байцаагч харьяалан шалган шийдвэрлэх зөрчилд энэ талаар заагаагүй. Ингэснээр Зөрчлийн тухай хуульд 14.15 дугаар зүйлд заасан “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих” зөрчлийг шалган шийдвэрлэх боломжгүй байна. Үүнтэй холбоотойгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд дээрх зүйлийг нэмэх төслийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас боловсруулжээ.³¹

Хувь хүн, сэтгүүлч, иргэний нийгмийн идэвхтнүүд өөрийн халдашгүй байдлыг хамгаалах буюу өөрийгөө хууль бус тагнах үйл ажиллагаанд өртөж байгаа эсэх, хууль бус нууц камерын бичлэгт өртөж байгаа эсэхээ шалгах боломжтой байдаг. Тиймээс бусад оронд нууц камер илрүүлэгч, чагнах төхөөрөмж илрүүлэгч буюу илрүүлэх зориулалттай техник хэрэгслийг олон нийтэд чөлөөтэй худалдаалдаг. Хамгийн энгийн жишээ нь дэлхийн онлайн худалдааны сайтуудад *Hidden Camera Detector*, *Spy camera detector*, *bug hunter* зэрэг нэрийн дор эдгээр төхөөрөмжийг худалдаалж байна. Гэтэл УИХ-аас 2020 оны 1 сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулийн 21.13 дугаар зүйлийн 2-т “...гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн хэсэг, Гүйцэтгэх ажлын тухай хуульд 2015 оны 7 сарын 9-ний өдрийн хуулиар шинээр нэмэгдсэн хэсэг болох 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг буюу “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж ... 'илрүүлэхэд' зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэсэн хэсэг дээрх боломжийг хязгаарлаж, жирийн иргэн ийм илрүүлэх төхөөрөмж авах, ашиглахыг гэмт хэрэг болгосон. Иймд иргэн П.Ундрах-Эрдэнэ, Л.Галбаатар нар хамтран Цэцэд мэдээлэл, гомдол гаргасан байх бөгөөд үүний дагуу 2023.05.17-ны өдөр Цэцийн дунд суудлын хуралдаанаар Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...” гэж заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоож улмаар тус заалтыг түдгэлзүүлсэн. Гэвч Цэцийн энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай УИХ-ын 2023.06.08-ны өдрийн 41 дүгээр тогтоол гарсан, Цэцийн их суудлын хуралдаанаар 2023.11.15-ны өдөр гаргасан тогтоолдоо “Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна. Хүний эрхийг баталгаажуулах хүрээнд Гүйцэтгэх ажлын тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгон нэр томъёог хоёрдмол утгагүйгээр хуульчлах нь зүйтэй байгааг тэмдэглэж байна” гэж дурдаад өмнөх дүгнэлтээ хүчингүй

³¹ Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авах тухай <https://mddc.gov.mn/mn/%d1%85%d1%83%d1%83%d0%bb%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/>

болгосон. Энэ нь сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг дордуулсан үр дагавартай шийдвэр болжээ.

УИХ-аас Засгийн газар дахь хяналтын тухай хуулийг 2022.11.11-ний өдөр баталж, 2023.01.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байна. Энэ хуулийн үйлчлэлд яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хамаарна. Тус хуулийн 5.1.5-т “ил тод, нээлттэй байдлыг хангах үйл ажиллагаа”, 5.1.6-д “мэдээлэл авах эрхийг хангах үйл ажиллагаа”-нд хяналт тавихаар заасан. Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар ажиллах бөгөөд түүнд Ерөнхий хянан шалгагч, ахлах хянан шалгагч, хянан шалгагч, бусад албан хаагч ажиллана. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга бөгөөд Ерөнхий хянан шалгагч байна. Гэхдээ ил тод, нээлттэй байдлыг хангах, мэдээлэл авах эрхийг хангах үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавих талаар холбогдох хууль болон дүрэмд тусгайлан заагаагүй байна.

УИХ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023.06.16-ны өдөр баталсан бөгөөд тус хуулийг 2024.01.01-ний өдрөөс мөрдөж байна. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.10-т “Засгийн газрын бодлого, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт болон цаг үеийн шинжтэй мэдээллийг яаралтай олон нийтэд хүргэх, мэдээлэхэд шаардлагатай хэвлэл мэдээллийн үйлчилгээ, ...-г худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно” гэж, 31.4-т “Захиалагч энэ хуулийн 10.8, 10.10-т заасан тохиолдолд энэ хуулийн 31.1.3, 31.1.4-т заасан аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж болно” гэж тус тус заасан. Энэ нь Засгийн газраас хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ шууд байгуулах замаар “хаалтын гэрээ” байгуулах буюу хэвлэл мэдээллийн байгууллагад далд хэлбэрээр төлбөр төлөх, улмаар тэдгээрийн редакцын бодлогод нөлөөлөх үр дагавартай юм. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023–2030 он/-ийн 3.4.3-т “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг баталж, мөрдүүлнэ” гэх заалт нь хуулийн дээрх зохицуулалтын үр дагаврыг арилгахад хангалтгүй бөгөөд Засгийн газраас ямар хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулахаа өөрөө шууд сонгох, ямар хэмжээний төлбөр төлөхийг хязгаарлах зохицуулалт болж чадахгүй.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас боловсруулж, олон нийтээс санал авахаар цахим хуудаастаа нээлттэй байршуулсан.³² Энэ төсөлд Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвшүүлэхгүй этгээдийг нэрлэн заажээ. Үүнд: төрийн улс төрийн албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн гаргасан хувьцааны тав ба түүнээс дээш хувийг эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд, Зохицуулах хорооны Ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн удирдах албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд байхаар заажээ. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газар, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тус бүр 2 нэр дэвшигчийг санал болгоно гэжээ. Энэ нь Харилцаа холбооны зохицуулах хорооны хараат бус байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтын төсөл байх боловч тус хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох, төрийн захиргааны албан хаагч тус хорооны гишүүнээр томилгодох нөхцөлийг хаагаагүй, томилгоонд иргэний нийгмийн оролцоог хангаагүй зэрэг сул талтай байна.

³² Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авах тухай <https://mddc.gov.mn/mn/%d1%85%d1%83%d1%83%d0%bb%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/>

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн нар Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслүүд болон холбогдуулан боловсруулсан бусад хууль, тогтоолын төслүүдийг 2024.04.05-ны өдөр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлсэн.³³ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 23.8.12-т Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудалд “хэвлэл мэдээллийн хараат бус байдал” гэж заасан. Энэ нь одоогийн хүчин төгөлдөр хуулийн 24.7.10-т байгаа зохицуулалтыг хэвээр хадгалсан болохыг харуулж байна. Харин одоогийн хуулийн 22.19-т “Иргэд, дотоод, гадаадын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжлага хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг Улсын Их Хурлын дарга батална” гэж заасныг хуулийн төслийн 38.4-т “Иргэд, дотоод, гадаадын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжлага хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална” гэж өөрчилсөн байна. Ингэснээр хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжлага хийх эрхтэй холбоотой харилцааг УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга тодорхойлох болж байна. Мөн тус хуулийн төслийн 38.3-т “Улсын Их Хурал чуулганы хуралдааныг шууд нэвтрүүлэх, үйл ажиллагаа, батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах телевиз, радиогийн тусгай сувагтай байж болно” гэж шинээр нэмсэн нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

³³ УИХ-ын тухай, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай, УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг өргөн мэдүүлэв <https://www.parliament.mn/nn/52156/>

ХОЁР. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭСРЭГ ИРГЭНИЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

2.1. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн эсрэг гомдол, мэдээлэл ба эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

Улсын Ерөнхий прокурорын газрын 2024.04.15-ны өдрийн мэдээллээр, 2023, 2024 оны эхний гурван сарын байдлаар шүүхээс 2 сэтгүүлчийг Эрүүгийн хуульд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.³⁴

ГИТ-өөс сэтгүүлч холбогдсон зарим гэмт хэргийн тоон мэдээллийг ЦЕГ-аас хүссэн бөгөөд ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтсийн өгсөн мэдээллээр цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022-2023 он, 2024 оны 1 дүгээр улиралд Эрүүгийн хуулийн 17.6 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх” гэмт хэрэг 115, 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэг 36, 21.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах” гэмт хэрэг 8 бүртгэгджээ. Мөн Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд заасан “Төрийн нууцыг хууль бусаар олж авах” гэмт хэрэг бүртгэгдээгүй гэжээ. Харин Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023.12.28-ны өдрийн мэдээлэлд “Прокуророос сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг ...төрийн нууцыг хууль бусаар олж авах гэсэн 1 үйлдэлд тус тус эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан” гэж мэдээлжээ.³⁵

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зохицуулалт ба бодит үйл баримт (факт) яв цав тохирсон үед тухайн зүйл, заалтыг хэрэглэх ёстой бөгөөд үүнийг хууль зүйн шинжлэх ухаанд “зүйлчлэх” гэдэг. Гэвч тухайн зүйл, заалтын зорилго, хамрах хүрээг бүхэлд нь хэрэглэхгүйгээр тусад нь салгаж сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны үйл ажиллагаанд цензур тогтоох гэсэн оролдлого гарах болов. Мэдээлэл тараахтай холбоотой дараах гэмт хэрэг байна. Тухайлбал,

- 17.6 дугаар зүйл (Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх)-ийн 1-т “Бусдыг эд хөрөнгө, эдийн, эдийн бус хөрөнгийн эрхээ шилжүүлэн өгөхийг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор үршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- Эрүүгийн хуулийн 18.11 дүгээр зүйл (Хууль бусаар дампууруулах)-ийн 1-т “Дампууруулах ноцтой үндэслэл бий болоогүй байхад хүчээр, хууран мэхэлж, гарцаагүй байдалд оруулж дампууруулсан; хуулийн этгээдийн талаар хуурамч мэдээлэл тарааж, гүтгэж, зориуд өр төлбөрөө өгөхгүй байж дампуурахад хүргэсэн; төрийн албан хаагч төрөөс үзүүлэх ёстой үйлчилгээг хуулийн дагуу үзүүлээгүй, зохих ёсоор бүртгээгүй, тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцалсан, үндэслэлгүйгээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг үндэслэлгүйгээр хугацаа хоцроож олгосны улмаас хуулийн этгээд дампуурсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйл (Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх)-ийн 1-т “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор үршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

³⁴ Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны талаарх гомдлын дийлэнх хувийг иргэдээс гаргажээ

<https://prokuror.mn/post/111820>

³⁵ “Шүүхийн мэдээ” 2023.12.29

https://www.facebook.com/story.php?story_fbid=678759491098268&id=100068926700796&rdid=fbuzsr1DcF2PcF6J

- Эрүүгийн хуулийн 23.7 дугаар зүйл (Нийтийн албан тушаалтныг заналхийлэх)-ийн 1-т “Нийтийн албан тушаалтныг тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахгүй байх, үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн; эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 1.8-д “Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно” гэж заасны дагуу сэтгүүлч мэргэжлийн дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлж нийтлэл, сурвалжилгад холбогдох этгээдээс энэ тухай хэлж, тайлбар авах гэсэн мэргэжлийн үйл ажиллагааг “эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн” гэж буруутгах эрсдэлтэй байна.

Түүнчлэн энд дурдсан “ноцтой хор уршиг”-ийн ойлголтыг ноцтой биш хор уршигийн асуудалд ч хамаатуулах эрсдэлтэй байна. Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйл (Гэмт хэргийн хохирол, хор уршиг)-ийн 3-т “Энэ хуульд заасан ‘ноцтой хохирол, хор уршиг’ гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно” гэж заасан. Тодруулбал, тухайн нийтлэл, мэдээлэлд дурдсан этгээдийн эрх, ашиг сонирхол хөндөгдсөнийг түүнд ноцтой хор уршиг учирсан гэж үзэхгүй.

Тайлангийн хугацаанд буюу 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр 45 шийдвэр байна. Үүнээс улс төрч, төрийн өндөр албан тушаалтны эсрэг шүүмжлэлт дуу хоолойг хязгаарлаж эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдлыг авч үзье.

- Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2023.05.22-ны өдрийн шийтгэх тогтоолоор иргэн Б-гийн 2023.04.23-ны өдөр Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн гэрэл зургуудыг ашиглан төрийн ордны хашааны завсраар харж байгаа болон буутай зургийг эвлүүлэн бэлтгэж, түүнийгээ фэйсбүүкт байршуулсан үйлдэлд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ. Энэ нь уран сайхны аргаар төрийн ордны хашааг ногооноор будсан ба Ерөнхийлөгч У.Хүрэлсүх галт зэвсэгтэй харьцаж буй үйлдлийг шүүмжилсэн илэрхийлэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа явдал юм.
- Сонгинохайхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2023.10.13-ны өдрийн шийтгэх тогтоолоор иргэний 2019.05.16, 2022.09.09, 2023.04.16-ны өдрүүдэд тухайн үеийн Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийн гэрэл зургийг байршуулан “Хамгийн худалч, Хамгийн популист, Хамгийн чалчаа, Хамгийн шударга ёс царайлагч, Хамгийн боловсрол муутай, Хамгийн биеэ гайхуулагч, Хамгийн Путинг дуурайгч, Хамгийн хамгийн хамгийн Ерөнхий сайд мину зээ”, “6 жил 205 км дарханы замыг тавьж чадаагүй хүн, 2,5 жилийн дотор 240 км Төмөр зам тавьчихлаа гэнээ”, “Хайр хүндлэл үгүй Ерөнхийлөгч байх үед... Аваргын цом гардуулахаар ордонд орж ирэв. Хөгжөөн дэмжигчид ҮҮҮҮҮҮ гэж угтав” гэсэн утгатай бичвэрийг фэйсбүүк, твиттерт нийтэлсэн үйлдэлд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ. Энэ нь Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийн үйл ажиллагааг шүүмжилсэн илэрхийлэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа явдал юм.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн талаарх НҮБ-ын Хүний эрхийн хорооны тайлбарт “Үзэл бодлоо илэрхийлэх хэлбэрүүд нь нийтийн албан тушаалтныг доромжилсон гэж үзэх энгийн баримт нь шийтгэл ногдуулах, нийтийн албан тушаалтнуудыг Пактын зүйл заалтыг ашиглан хожих хангалттай үндэслэл болохгүй. Үүнээс гадна төрийн болон засгийн газрын тэргүүн зэрэг улс төрийн өндөр эрх мэдэлтнүүдийг оролцуулан нийтийн бүх албан тушаалтан хууль ёсны дагуу шүүмжлэл, улс төрийн сөрөг

хүчний анхааралд байна. Иймд эрхэм дээдэс, эрх мэдэлтнийг үл хүндэтгэх, үл хүндэтгэх ёс (desacato), далбаа, бэлэг тэмдгийг үл хүндэтгэх, төрийн тэргүүнийг гутаан доромжлох, төрийн албан тушаалтны нэр төрийг хамгаалах гэх мэт хууль тогтоомж нь Хорооны санааг зовоож байна. Хууль тогтоомж нь гагцхүү худал эсвэл буруу гэх дайралтад өртсөн бие хүнийг өмгөөлөхөд үндэслэгдсэн хатуу шийтгэл ногдуулах ёсгүй. Гишүүн улс арми, захиргааны гэх мэт байгууллагыг шүүмжлэхийг хориглох ёсгүй” гэж онцолжээ. Энэ нь төрийн албан тушаалтны нь хувиар шүүмжилсэн, зөвхөн хувь хүнд хамаарах нэр төр, алдар хүнд гэх ойлголтыг шүүхийн практикт ялгаж, салгахгүйгээр, хүний эрхийн олон улсын хэм хэмжээнээс гажуудуулан хэрэглэж байгааг харуулж байна.

2.2. Сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг мөрдөн шалгах ажиллагаа

Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг zarig.mn сайтын эрхлэгч, сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг фэйсбүүк дэх хуудсаараа өндөр настай хүн оролцож буй шүүх хуралдааныг олон цагаар үргэлжлүүлэн явуулж байгаа нь хүнлэг бус явдал гэх утгатай нийтлэл оруулсантай нь холбоотойгоор Шүүхийн ерөнхий зөвлөлөөс мөрдөн байцаах байгууллагад 2023 онд гомдол гаргасан. Үүний дагуу сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт яллагдагчаар татсан байна. Энэ зүйлд зааснаар “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

Энэ зүйл, заалт нь шүүгчийн хараат бус байдал, ажил хэргийн нэр хүндэд халдсан гэх гомдолтой хамааралгүй бөгөөд зөвхөн хувь хүний нэр төр, алдар хүндийг хамгаалахтай холбоотой зохицуулалт юм. Эрүүгийн хуульд “21.6 дугаар зүйл.Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуульд “15.4 дүгээр зүйл.Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөхийг оролдох” гэмт хэрэг, зөрчлийг зохицуулсан бөгөөд эдгээр гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй үйлдлийг “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт хамаатуулан шалгажээ.

Түүнчлэн Чингэлтэй дүүргийн прокурорын газраас “...Өөрийн цахим хаяг болох “Unurtsetseg Naran” гэх фэйсбүүк хаягаар шүүгчийн ажил хэргийн нэр хүндэд халдсан, олон нийтийг төөрөгдүүлсэн илт худал мэдээллүүдийг олон нийтийн цахим сүлжээ буюу фэйсбүүк орчинд тараасан” гэх хэрэгт яллагдагчаар татагдсан сэтгүүлч Н.Өнөрцэцэгт Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналыг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд ирүүлсэн бөгөөд шүүхээс прокурорын саналыг хүлээн авч, 2023.11.29-ний өдрөөс сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг Монгол Улсын хилээр гарахыг хязгаарласан.

Үүнээс гадна Чингэлтэй дүүргийн прокурорын газраас “...тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хэргийн талаар цахим орчинд хандах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх...” таслан сэргийлэх арга хэмжээг авхуулахаар санал ирүүлснийг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдөр хянан хэлэлцсэн. Шүүхээс “сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлснээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан буюу мөрдөн шалгах ажиллагааг хуулийн хүрээнд явуулахад саад учруулах нөхцөл байдал тогтоогдоогүй байна. Хэргийн талаар цахим орчинд хандах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх гэсэн таслан сэргийлэх арга хэмжээг шүүхээс авах боломжгүй юм” гэж дүгнэсэн боловч “...мэргэжлийн үйл ажиллагаагаа ашиглан олон нийтийг төөрөгдүүлэх, тодорхой үйлдэлд уриалах, жагсаал цуглаан зохион байгуулах, хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаах, доромжлох зэргээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахуйц үйлдлийг хийх нь яллагдагчид хуульд заасны дагуу албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх, түүнд авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх үндэслэл болохыг анхаарах нь зүйтэй” гэсэн нь түүнийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбоотойгоор цагдан хорих эрсдэлтэй гэдгийг анхааруулсан байна.

Үүнээс хойш Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны 9/6-8665 тоот албан бичиг, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын 2023.12.01-ний өдрийн 116 тоот зөвшөөрлийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос zarig.mn цахим хуудсыг зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтад оруулсан буюу Монгол Улсаас хандах боломжгүй болгожээ. Энэ нь сэтгүүл зүйн үйл ажиллагаа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг шүүхийн шийдвэргүйгээр, захиргааны байгууллагаас хязгаарласан ноцтой асуудал юм. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 3 өдрийн дараа буюу 2023.12.04-ний өдөр прокурорын тогтоол, Мөрдөн байцаах албаны шийдвэрийн дагуу zarig.mn цахим хуудсыг зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтаас хассан.

Мөн сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг “мөрдөгч нараас 21 удаа утсаар ирэхийг мэдэгдсэн боловч ирээгүй учраас прокуророос мэдэгдэх хуудсаар 6 удаа дуудахад 3-т нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, саад учруулах үйлдлийг удаа дараа гаргаж байгаа нь хуульд заасан яллагдагчийн хүлээсэн үүргийн зөрчилд хамаарах” тул прокурорын цагдан хорих саналыг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгчийн 2023.12.04-ний өдрийн захирамжаар цагдан хорьсон.

Шүүхээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт “шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол цагдан хорино” гэдэг үндэслэлийг шүүхээс хэрэглэсэн. Энэ заалтыг барьсан бололтой. Шүүгч захирамждаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж байна гэдэг прокурорын үндэслэлийг онцолсон бөгөөд хүнийг заавал дуудаж мэдүүлэг авах нь зайлшгүй ажиллагаа биш төдийгүй буруутгагдаж буй гэмт хэрэгт оноох торгох шийтгэлээс нь хүнд хэлбэрээр хүнийг цагдан хорьж болох зохицуулалт үйлчилж байна. Энэ зохицуулалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 3-т “Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Үүнээс хойш 68 хоногийн дараа буюу Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгчийн 2024.02.09-ний өдрийн захирамжаар “яллагдагч Н.Өнөрцэцэгийн ар гэрийн нөхцөл байдал, үр хүүхдүүдийнх нь эрх ашгийг харгалзан түүнд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг энэ өдрөөс өөрчилж, Н.Өнөрцэцэгийг холбогдсон эрүүгийн хэрэг нь хянан шийдвэрлэгдэж дуусталх хугацаанд Монгол Улсын хилээр гарч явахыг хязгаарлах, мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахаар эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад очих, өөрийн холбогдон шалгагдаж байгаа хэргийн асуудлаар хуулийн байгууллагад очихоос өөр бусад газарт очихыг хязгаарлах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг тус тус авч шийдвэрлэсэн”. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 1-т зааснаар яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар хүртэл байх ба 2-т зааснаар яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах ба яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг таван жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 6 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг таван жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй.

Нийслэлийн Прокурорын газраас яллагдагч Н.Өнөрцэцэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх зорилгоор “Зариг.мн” сайтын нэрийн өмнөөс эрхлэгч, сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг түүнд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлэх саналыг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр ирүүлсэн байх бөгөөд Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024.04.05-ны өдрийн захирамжаар “Шүүх саналыг хүлээн авч хянан хэлэлцээд яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, яллагдагчийн хувийн байдал болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор яллагдагч Н.Өнөрцэцэгт холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж дуусах хүртэл хугацаанд

сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг түдгэлзүүлж шийдвэрлэв”. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйлийн 1-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч саад учруулахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор төрийн албанд ажиллах, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, эсхүл тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг прокурорын саналыг харгалзан шүүхийн зөвшөөрлөөр авч болно” гэж заасан хэдий ч “саад учруулах” ойлголтыг тус хуульд тодорхойлоогүй, сэтгүүлчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл шаардаггүй бөгөөд Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор хязгаарлаж болохгүй гэдгийг прокурорын санал, шүүхийн шийдвэрт харгалзаж үзсэнгүй. Прокурорын хувьд “мэргэжлийн давуу байдлаа урвуулан, зохисгүй зураг, дүрс ашиглаж, өөрт нь хуулийн дагуу авсан таслан сэргийлэх арга хэмжээг мушгин гуйвуулж, олон нийтэд буруу ойлголт мэдээлэл өгч байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, шүүгч, прокурорын хараат бус байдалд нөлөөлөх гэсэн оролдлого” гэж тайлбарлажээ.³⁶

Иймд Сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очихыг хориглосон, сэтгүүлчийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарласан, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйтэй холбоотой асуудлыг эрүүгийн хэргийн журмаар мөрдөн шалгаж, яллаж байгаа нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан олон улсын гэрээ, Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй төдийгүй, сэтгүүл зүйн үйл ажиллагаанд цензур тогтоож байгаа практикийг халах шаардлагатай байна.

2.3. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн тойм

Тайлангийн хугацаанд буюу 2022 оны 5 дугаар сараас 2024 оны 4 дүгээр сарын байдлаар иргэний хэргийн анхан шатны шүүхээс гаргасан нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой хүчин төгөлдөр 20 шийдвэр байна. Үүнээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр төр, алдар хүндэд халдсан гэх нэхэмжлэлийг шүүхээс хэрхэн шийдвэрлэсэн зарим жишээг авч үзье.

- Нэхэмжлэгч Т.Б нь хариуцагч Б.Д-д холбогдуулан 2022.07.20-ны өдөр нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан болохыг тогтоолгох, нэр төрийг гутаан доромжилсон хэлбэрээр сэргээлгэх тухай нэхэмжлэлийг гаргаж, 2022.12.08-ны өдөр нэхэмжлэлийн шаардлагаа 2021.03.09-ний өдрөөс эхлэн олон нийтийн мэдээллийн сайтын нүүр хуудсанд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, бодит үнэнийг мушгин гуйвуулсан мэдээллийг олон янз байдлаар гарчиг тавин тараасаар байгаа учраас 11,000,000 төгрөг гаргуулах, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гүжир нийтлэлүүдийг интернэтээс устгуулж, нэр төр сэргээсэн мэдээллийг мэдээлэл тараасан нэр бүхий 25 мэдээллийн сайтуудад бүтэн 2 жилийн турш байршуулахыг тус тус хариуцагчид даалгуулахаар, мөн 2023.05.16-нд дээрх нийтлэлийн улмаас биеийн эрүүл мэнд эрс муудаж эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн зардал 2,220,000 төгрөгийг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлагаа тус тус ихэсгэсэн. Хариуцагч Б.Д нь 2021.03.09-ний өдөр өөрийн өмчлөлийн сайтын “Төрийн дайсан” гэх буландаа “Улсын төсвөөс охидоо хагас тэрбум төгрөгөөр сургууль төгсгөсөн төрийн албан хаагч Т.Б-ын тухай” гэсэн гарчигтай нийтлэл бичсэнээ хүлээн зөвшөөрч маргаагүй. Харин нэхэмжлэлийг бүхэлд нь эс зөвшөөрч байгаа үндэслэлээ дээрх нийтлэл нь бодит байдалд тулгуурласан, энгийн ардын хүүхдийн суралцах боломжийг хааж өөрийн төрсөн охидоо болон хамаарал бүхий этгээдүүдээ ИНЕГ-ын зардлаар гадаадад сургасан нь баримттай гэж маргасан. Шүүхээс “Хариуцагчийн дээрх нийтлэлийг бичих үндэслэл болсон баримтууд болон эх сурвалж нь хэрэгт авагдсан баримтууд, талуудын тайлбараар тогтоогдсон бөгөөд тэрээр нийтлэлийнхээ эх сурвалжийг тодорхойлсон тул нийтэлсэн мэдээ,

³⁶ Г.Гэрэлтуяа: ЭХХШ хуулийн дагуу Н.Өнөрцэцэгийн сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг түдгэлзүүлсэн <https://www.arслан.mn/social/news/656135.shtml>

мэдээллийнхээ бодит үнэнд нийцсэн байдлыг хариуцагч баримтаар нотолсон гэж үзнэ. Иймээс Т.Б-ын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан болохыг тогтоолгох, нэр төрийг гутаан доромжилсон хэлбэрээр сэргээлгэх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэх боломжгүй” гэж дүгнэжээ. Мөн “нэр бүхий 25 мэдээллийн сайт нь дээрх нийтлэлийг хариуцагчийн зөвшөөрөлгүйгээр шейрлэж өөрсдийн сайтуудаар дамжуулан нийтэлсэнд хариуцагч Б.Д буруугүй, түүний үйлдэлд хамааралгүй байна. Мөн нэхэмжлэгч нь эдгээр нэр бүхий 25 мэдээллийн сайтыг хариуцагчаар татан оролцуулаагүй болно. ... шүүх нэр төр сэргээлгэх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлээгүй учраас хариуцагчаас зардал гаргуулах боломжгүй” гэж дүгнэсэн ба Т.Б-ын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.³⁷

- Энэ хэргийг шийдвэрлэхдээ нэхэмжлэгч нь шүүхэд прокурорын байгууллагаас гаргасан баримт, мэдээллийг гаргаж өгчээ. Тухайлбал, Монгол улсын Ерөнхий прокурорын газрын 2022.05.31-ний өдрийн 1/1326 тоот “Гомдолд хариу өгөх тухай” хариу мэдэгдэх хуудас, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын 2022.03.15-ны өдрийн 5/336 тоот “Гомдлын хариу” гэх мэдэгдэх хуудас, Нийслэлийн прокурорын газрын 2017.03.07-ны өдрийн 37 тоот “Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” тогтоол, -Нийслэлийн прокурорын газрын 2016.02.01-ний өдрийн 01 тоот “Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн мөрдөгчийн тогтоолыг хүчингүй болгох тухай” тогтоолыг иргэний хэргийн шүүхэд өгсөн нь сэтгүүлчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж шийтгүүлж чадаагүй бол дараа нь иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, төлбөр нэхэмжлэх замаар сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд цензур тогтоох гэж оролдож байгааг харуулж байна. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын 2022.03.15-ны өдрийн 5/336 тоот иргэн Т.Б-д хүргүүлсэн “Хариу мэдэгдэх хуудас”-т “...Таны тус дүүргийн прокурорын газарт гаргасан гомдлын дагуу хэрэг бүртгэлтийн хааж шийдвэрлэсэн эрүүгийн дугаартай хэргийг хянав. Хэрэгт авагдсан үйл баримтуудаар 2021 оны 02 болон 03 дугаар саруудад цахим хуудсанд болон зэрэг мэдээллийн сайтуудаар дамжин “Улсын төсвөөс охидоо хагас тэрбум төгрөгөөр сургууль төгсгөсөн төрийн албан хаагч Т.Б” гэх мэдээллийг олон нийтэд тараасан байна. цахим хуудсанд дээрх нийтлэлд холбоотойгоор цугларсан баримтаар таны хамаарал бүхий хүмүүс сонгон шалгаруулалтад тэнцэж, ИНЕГ-ын зардлаар суралцсан үйл баримт тогтоогдсон байна. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараах гэмт хэргийн шинж нь бусдын нэр төр, алдар хүндийг гутаахад чиглэсэн ор үндэсгүй мэдээ, баримт сэлтийг ойлгохоор заасан. Энэ тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хуулиар гэмт хэргийн шинжийг тодорхойлсон “мэдээлэл илт худал” байх шалгуур үгүйсгэгдэж байх тул тус дүүргийн прокурорын газрын хяналтын прокурорын хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэв...” гэх, Монгол Улсын ерөнхий Прокурорын газрын 2022.05.31-ний өдрийн 1/1326 тоот гомдолд хариу өгөх тухай “Хариу мэдэгдэх хуудас”-т “Улсын ерөнхий прокурорын газарт хандаж гаргасан таны гомдлын дагуу Сүхбаатар дүүргийн прокурорын газраас эрүүгийн дугаартай, хааж шийдвэрлэсэн хэргийг татаж хянав. Хэргийг хянахад, сайтыг эрхлэн ажиллуулж байсан гэх Б.Д 2021 оны 03 дугаар сард Иргэний нисэхийн ерөнхий газраас зарласан сонгон шалгаруулалтад тэнцэж, тус газрын зардлаар Америкийн Нэгдсэн Улс, Канад, Англи зэрэг орнуудад суралцсан оюутнуудын дунд таны төрсөн охид болон хамаарал бүхий хүмүүс байсан талаар нийтлэлдээ дурдсан мэдээлэл нь илт худал мэдээлэл болох нь тогтоогдоогүй, мэдээллийн сайтад эх сурвалжтай баримтуудыг ашигласан бөгөөд та мөрдөн шалгах ажиллагааны явцад өгсөн мэдүүлэгтээ дээрх нийтлэлд дурдсан мэдээллийг үгүйсгээгүй байна...” гэх хариуг тус тус нэхэмжлэгчид хүргүүлж байжээ.

³⁷ Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023.06.16-ны өдрийн 01845 дугаартай шийдвэр https://shuukh.mn/single_case/128780?daterange=2022-05-01%20-%202024-04-24&id=1&court_cat=1&bb=1

Сэтгүүлчийн аюулгүй байдлын талаарх асуулгын судалгааны тойм

Глоб Интернэшнл төв нь Нээлттэй Нийгэм Форум болон Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжин хамгаалах /IFEX/ олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээлэлтэй байх, улс төрийн үйл явцад мэдээлэлтэй оролцох эрх” төслийн хүрээнд энэхүү судалгааг авсан болно.

Судалгааны зорилго:

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад тулгарсан мэргэжлийн эрхийн зөрчлүүдийг илрүүлэх, бүртгэх, нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулан цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зорилгоор судалгаа хийв.

Хамрах хугацаа:

2023.01.01-2024.04.20

Судалгааны хамрах хүрээ:

Улаанбаатар хотын болон орон нутгийн телевиз, сонин, сэтгүүл, радио, фм, цахим хуудасны нийт 386 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан хамрагдсанаас оролцогчдын 97 хувь нь Улаанбаатар хотын төлөөлөл, 3 хувь нь орон нутгийн төлөөлөл байна. Хүйсийн хувьд ангилан үзвэл судалгаанд хамрагдсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын 65 хувь нь эмэгтэй, 35 хувь нь эрэгтэйчүүд байв.

СЭТГҮҮЛЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ДҮН

Глоб Интернэшнл төв нь Нээлттэй Нийгэм Форум болон Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжин хамгаалах /IFEX/ олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээлэлтэй байх, улс төрийн үйл явцад мэдээлэлтэй оролцох эрх” төслийн хүрээнд энэхүү судалгааг авсан болно.

Судалгааны зорилго:

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад тулгарсан мэргэжлийн эрхийн зөрчлүүдийг илрүүлэх, бүртгэх, нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулан цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зорилгоор судалгаа хийв.

Хамрах хугацаа:

2023.01.01-2024.04.20

Судалгааны хамрах хүрээ:


Улаанбаатар хотын болон орон нутгийн телевиз, сонин, сэтгүүл, радио, фм, цахим хуудасны нийт 386 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан хамрагдсанаас оролцогчдын 97 хувь нь Улаанбаатар хотын төлөөлөл, 3 хувь нь орон нутгийн төлөөлөл байна. Хүйсийн хувьд ангилан үзвэл судалгаанд хамрагдсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын 65 хувь нь эмэгтэй, 35 хувь нь эрэгтэйчүүд байв.

СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС...

Хамгийн чухал аюулгүй байдлын асуудал

Хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг хүмүүсийн хувьд хамгийн чухал аюулгүй байдлын асуудал юу вэ? гэсэн асуултанд нэгдүгээрт “эх сурвалжийн аюулгүй байдал” гэж нийт оролцогчдын 65 хувь нь хариулсан бол “мэдээллийн аюулгүй байдал” гэж 63 хувь, “хувийн аюулгүй байдал” чухал гэж ойролцоо буюу 62 хувь нь хариулсан байна.

Хамгийн чухал аюулгүй байдлын асуудал юу вэ?




Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудад тулгардаг асуудлууд

Сэтгүүлч хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудад хамгийн их тулгардаг асуудлын нэгдүгээрт “мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалздаг” гэж 59 хувь нь хариулав. Харин “шүүх, цагдаа, прокуророос дуудах” гэж 31 хувь, “Утасны яриа чагнах, бичлэг хийх” гэж 16% нь тус бүр хариулжээ.

| № | Асуудлууд | Эзлэх хувь |
|----|------------------------------------------------------|------------|
| 1 | Мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзах | 59% |
| 2 | Шүүх, цагдаа, прокуророос дуудах | 31% |
| 3 | Утасны яриа чагнах, бичлэг хийх | 16% |
| 4 | Цахим шууданд халдах | 15% |
| 5 | Биетээр халдах | 12% |
| 6 | Мэдээлэл хулгайлах | 12% |
| 7 | Биечлэн заналхийлэх | 10% |
| 8 | Техник технологид халдах /вирус тараах/ | 9% |
| 9 | Бусад | 8% |
| 10 | Хууль бусаар баривчлах | 7% |
| 11 | Ажлын онлайн орон зайд халдаж, мөрдлөг хийх, хакдах | 7% |
| 12 | Хувийн онлайн орон зайд халдаж, мөрдлөг хийх, хакдах | 7% |
| 13 | Найз нөхөд, гэр бүл, хамтран ажиллагсдыг заналхийлэх | 7% |
| 14 | Нэгжлэг үзлэг | 3% |


Эрх зөрчигч субъектууд

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын эрх ашгийг ямар субъект хамгийн их зөрчдөг вэ? гэсэн асуултад 386 хүний 58 хувь нь “эрх мэдэл бүхий албан тушаалтнууд” гэж хариулсан нь анхаарал татахуйц байна.




Эрх зөрчигдсөн байдал

Судалгааны хамрах хугацаанд “Ажил үүргээ гүйцэтгэх явцад эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн” гэж судалгаанд оролцогчдын 24 хувь хариулсан бол эрх зөрчигдсөн эсэхээ “мэдэхгүй” гэж талаас илүү хувь нь хариулжээ.



Таны ямар эрх зөрчигдсөн бэ?

Ямар эрх зөрчигдсөн гэсэн асуултад “мэдээлэл авах, боловсруулах эрх” зөрчигдсөн гэж 75 хувь, “хэвлэн нийтлэх эрх” гэж 55 хувь нь, “эх сурвалжаа хамгаалах эрх” гэж 48 хувь нь тус тус хариулсан байна.




Таны эрх хэзээ зөрчигдсөн бэ?

2023-2024 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар эрх нь зөрчигдсөн гэж хариулсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд бүгд 2023 онд эрх зөрчигдсөн гэж хариулжээ.


Сэтгэл зүйн дарамт, хохирол амсдаг эсэх

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын 89 хувь нь сэтгэл зүйн дарамтад ямар нэгэн байдлаар ордог гэж хариулжээ. Харин сэтгэл санааны дарамтад хэр давтамжтай ордог вэ? гэсэн асуултад “байнга” гэж 13 хувь нь, “ихэвчлэн” гэж 76 хувь , нь хариулсан бол “заримдаа” гэж 11 хувь нь хариулав.



Ажлын техник хэрэгсэл, эд хогшилд халдсан эсэх

Судалгаанд оролцогчдын 14 хувь нь ажлын техник хэрэгсэл, эд хогшилд халдсан гэж хариулснаас 1-2 удаа халдсан хэмээн 83 хувь нь, 3-4 удаа гэж 17 хувь нь хариулав.




“Сүүлийн 12 сарын хугацаанд сэтгүүлч нарт дараах асуудлууд тохиолдсон уу?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд дараах байдлаар хариулав.



Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад тулгарч буй дээрх асуудлуудыг бууруулахын тулд авч хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэмжээ бол эрх зүйн орчныг сайжруулах гэж нийт оролцогчдын 75 хувь нь хариулав.



Сэтгүүлчдэд тулгарсан тохиолдлууд:

- “А”-сайтын эрхлэгчийн ээжийн гэрт цагдаа очиж нэгжлэг хийсэн. Түүний гар утас, нөхрийн утас, нөүтбүүк зэргийг эд мөрийн баримтаар авч, сэтгүүлчийг байцаахаар 12 цаг суулгасан. Энэ үед сэтгүүлчийн бие муудаж эмийг нь уулгалгүй эрүүдэн шүүсэн.
- Цагдаагийн байгууллага амралтын өдөр дуудаж айлган сүрдүүлсэн нь хэвлэн нийтлэх эрхэд халдсан.
- Тухайн байгууллагыг намаас хүн томилж удирдуулсан тохиолдолд байгууллагын төлөвлөсөн бодлогод нөлөөлөх тохиолдол байдаг.
- Эрх мэдэлтэн сэтгүүлчдийн утсыг чагнадаг байсан.
- 2023 оны болсон хэргийг улс даяараа мэдэж байгаа. Сайтын сэтгүүлчид асуудлаа ярьж заналхийлсэн тухай лайв, бичлэг өөрийн цахим хуудсандаа нийтэлсэн байна.
- Зариг.мн сайтын Өнөрцэцэгийн кейсийг бүх л сэтгүүлч анхааралтай харж байна.
- Номин дэлгүүрийн хамгаалагч халдаж байсан. “Terranova” дэлгүүр тааз нурсан.
- Зариг.мн сайтын сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг дур зоргоор баривчилж цагдан хорьсон.
- Таньдаг сэтгүүлчид ихэвчлэн шүүхэд дуудагдсан гэдгийг сонссон.
- Нэг намыг сурталчлах талаар санал тавьсан.
- Ажиллах хүсэл эрмэлзлийг унтрааж, зөв чиглүүлдэггүй, дэмждэггүй.
- Иргэн биед халдаж, хувцсыг нь урж байсан.
- Хууль бусаар биед нь халдаж цагдан хорьсон, эрүүдэн шүүсэн
- Сэтгүүлч охин, зураглаачийн техникт халдаж байсан тохиолдол харж байсан.
- Албан тушаалтай дарга нар их дарамт үзүүлдэг.
- Чагнах төхөөрөмж суурилуулсан тухай мэдээ ирсэн.
- Ярилцлага өгсөн эх сурвалж өөрийнх нь яриаг дутуу оруулсан гэж доромж үгээр хараасан. Шинэ залуу сэтгүүлчдийг туршлага дутмаг гэж элэг барьж биед нь зүй бусаар халдах гэсэн оролдлого хийж байсан.
- Хувийн хандлагаараа сэтгүүлч, эвлүүлэгчдэдээ хандаж уур бухимдлаа гаргадаг.
- Сэтгүүлч намайг цагдан хорих гурван удаагийн шүүх хурал болсон, 30+ хэрэгт холбогдуулан шалгаж эрүүдэн шүүсэн. Биед болон камер техникт удаа дараа халдаж байсан, заналхийлэлд өртдөг.
- Миний мэддэг таньдаг сэтгүүлчдийг хилс хэрэгт оруулж хорьж байсан.
- Цагдаа нар эх сурвалжаа хэлэхийг шаарддаг. Эх сурвалжаа хамгаалах эрхийг олж авах шаардлагатай байна.

Сэтгүүлчдийн аюулгүй байдал, эрхийн асуудлаарх дээрх асуултад дурдагдаагүй нэмж хэлэх санал байна уу?

- *Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах эрхийг хуульчилж оруулж өгөх шаардлагатай байна. Түүнчлэн хуульд сэтгүүлчдийн мэдээлэл олж авах эрхийг мөн нарийн тусгах шаардлагатай байна.*
- *Эрх зүйн орчныг сайжруулах, эх сурвалжаа хуулиар хамгаалах.*
- *Чөлөөт зах зээл, чөлөөт хэвлэл байгаа бол сэтгүүлч чөлөөтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.*
- *Сэтгүүлчдийг Эрүүгийн хуулиар шийтгэдэг байдлыг зогсоомоор байна.*
- *УИХ-ын ... гишүүнтэй гэрээ байгуулсан тул мэдээллийг хэвлэн нийтлэхгүй гэдэг.*
- *Сэтгүүлчид өөрсдөө бусдын аюулгүй байдал, эрхийг зөрчиж, бүдүүлэг, ёс зүйгүй байдаг.*
- *Сэтгүүл зүйн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн ашиг орлого цалин нэмэгдэж байж энэ бүх асуудал дээрдэнэ. (Эрүүл орлого)*
- *Монголын ихэнх сэтгүүлчид худалдагдсан!*
- *Төрийн захиргааны байгууллагууд хяналт шалгалт хийн албаны дарга нарыг ёс зүйн зарчмаар ажиллуулах тогтолцоо хэрэгждэг.*
- *Хууль санаачлагчид хэтэрхий дураараа хууль баталж хэрэгт холбогдуулж яллаж байна.*
- *Байгууллагуудын олон нийттэй харилцах мэргэжилтэн, хэвлэлийн төлөөлөгч зэрэг нь мэдээлэл олж авахад үүргээ биелүүлж, саад тотгорыг шийдвэрлэн албаны хүнтэй холбоод өгдөг байгаасай.*
- *Мэдээлэл авах, тодруулж асуух үед төрийн албан хаагч удирдлагууд цааргалдаг. Ихэвчлэн удирдлагаасаа зөвшөөрөл авна гээд мэдээлэл өгдөггүй, бараг зугтдаг.*
- *Улс төрч, эрх мэдэлтнүүдийн ажлаа мэддэггүй, ажлаа бүлэглэл маягаар явуулдаг нь аль ч салбарт муугаар нөлөөлж, ахиц дэвшилд хүрэхгүй байна гэж үзэж байна.*
- *Бэлгийн дарамтад өртдөг.*
- *Хууль, эрх зүйн болон улс төрийн орчныг сайжруулах шаардлагатай.*
- *Сэтгүүл зүйн бүх чиглэлээр ажиллахад эдийн засгийн эрх чөлөө дутагдалтай байдаг.*
- *Ямар ч хамгаалалт эрх зүйн орчин байхгүй.*
- *Сэтгүүлчдийн олон нийтийн дунд эзлэх байр суурийг сайжруулж, хэм хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.*
- *Хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө эдлэхийн төлөө Эрүүгийн хуулийн 13.14 дэх заалтаар яллагдагч болгож, түүгээр байнга хуулийн байгууллагад хандаж, ажлаа хийхэд дарамт болдог нь харамсалтай.*
- *Сэтгүүлчдийн өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх арга барилыг сайжруулах.*
- *Шударга ёсыг тогтоож, хэвлэлийн эрх чөлөөтэй нийгмийг бүтээхийг хүсэж байна.*
- *Эх сурвалжаа нууцлах эрхтэй, мэдээлэл авах эрхээ авч үлдмээр байна.*